

**“ХҮҮХЭД, ӨСВӨР НАСНЫХНЫ МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСТ АВТАХ ЭРСДЭЛ, ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ” КРИМИНОЛОГИ СУДАЛГААНЫ Т А Й Л А Н**

**НЭГ. СОЦИОЛОГИ СУДАЛГААНЫ ХЭСЭГ**

**1.1 Сурагчдын дунд зохион байгуулсан санал асуулга, ярилцлага**

**1.1.1 Судалгааны зорилго, зорилт, арга зүй**

Хүүхэд өсвөр насныхны дунд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ, эрсдэлийг судлах тэдгээрт автах эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга замыг асуулга, ярилцлагын аргаар тодорхойлох.

**1.1.2 Судалгаанд оролцогчид, хугацаа, хамрах хүрээ**

Нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Сонгино-хайрхан дүүрэг, Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул аймгуудын ерөнхий боловсролын сургуулийн 1067 хүүхдийг хамруулан 2017 оны 10 дугаар сарын 23-наас 11 дүгээр сарын 26-ны хооронд тест болон ярилцлагын аргаар авсан судалгааг статистикийн SPSS программаар боловсруулж, дүгнэлт хийж нэгтгэлээ. Үүнд:

**1.1.3 Судалгааны нэгтгэсэн үр дүн**




График 1




График 2





График 3

Судалгаанд орон нутаг болон нийслэлийн нийт 1067 сурагч оролцсоноос 529 нь эрэгтэй, 538 нь эмэгтэй сурагч байна. /график 1/ Үүнээс 7 дугаар ангийн 60 хүүхэд, 8 дугаар ангийн 157 хүүхэд, 9 дүгээр ангийн 215 хүүхэд, 10 дугаар ангийн 243 хүүхэд, 11 дүгээр ангийн 189 хүүхэд, 12 дугаар ангийн 203 хүүхэд оролцсон байна. /график 2/




Судалгаанд оролцогчдын хувьд энэ төрлийн бодисын талаар ер нь сонсдог 37%, заримдаа сонсдог 41%, маш их сонсдог 18% бол огт сонсоогүй 4% байна. ЕБС-ийн сурагчдын 96% нь мансууруулах бодисын талаар мэдээлэлтэй байна /График 3/. Судалгаанд оролцогчдын 28% нь мансууруулах бодисын талаарх мэдээллийг телевиз, киноноос, 27% нь интернэт, 15% сонин сэтгүүл, 10% нь гэр бүл хамаатан садан, 12% нь найз


нөхдөөс мэдээлэл авсан гэсэн бол 4% нь энэ талаарх мэдээлэл огт аваагүй байна /График 4/.




Судалгаанд оролцогчдын 41% нь мансууруулах бодисын хэрэглээ өсвөр үеийнхний дунд түгээмэл байдаг, 15% нь маш түгээмэл, 20% нь мэдэхгүй, 13% нь бага, 5% нь маш бага, 6% нь түгээмэл бус байдаг гэж үзжээ /График 5/.



Судалгаанд оролцогчдын 44% нь уг бодисын 1-3 төрөл, 21% нь 3-5 төрлийг мэднэ, 20% нь огт мэдэхгүй, 5% нь 5-8 төрөл, 10% нь 8-аас дээш төрлийг тус тус мэднэ гэсэн байна /График 6/.




Судалгаанд оролцогчдын 320 нь мансууруулах бодис хэрэглэсэн хүн огт хараагүй, 230 нь 1-2 хүн харсан, 70 нь 3-5 хүн харсан гэсэн бол 447 нь мансууруулах бодис хэрэглэсэн олон хүн харсан гэсэн байна /График 7/.




Судалгаанд оролцогчдын 74% нь мансууруулах бодис огт хэрэглэж байгаагүй, 13% нь ганц удаа хэрэглэж байсан, 2% нь хааяа хэрэглэдэг гэсэн бол 11% нь олон удаа хэрэглэж байсан гэсэн байна /График 8/.

Та энэ төрлийн бодисын хор уршиг, урьдчилан сэргийлэх талаар хичээл сургалт болон хичээлээс гадуур сургалтанд хамрагдаж байсан уу?




Судалгаанд оролцогчдын 28% нь мансууруулах бодисын хор уршиг, урьдчилан сэргийлэх талаар интернэтээс үзсэн, 31% нь хичээлээр судалсан, 19% нь энэ талаар мэдэхгүй, 14% нь найз нөхөд, хүрээлэн буй хүмүүсээс судалсан бол 6% нь хувиараа судалсан байна /График 9/.

Хэн нэгэн мансууруулах бодисын хор уршгийн талаар хэлж хол байх тухай зөвлөж байсан уу?




Хэн нэгэн мансууруулах бодисын хор уршгийн талаар танд хэлж хол байх тухай зөвлөж байсан уу? гэсэн асуултад сурагчдын 46% нь маш их зөвлөдөг, 25% нь хааяа зөвлөдөг, 17% нь ганц хоёр удаа л зөвлөж байсан гэсэн бол 12% нь огт зөвлөж байгаагүй гэсэн байна /График 10/.

Танай үеийнхэнд мансууруулах бодисын хор хөнөөлийн талаар хичээл, сургалт явуулах хэрэгцээ шаардлага бий юу?



Судалгаанд оролцогчдын 34% нь ер нь шаардлагатай, 31% нь маш их шаардлагатай, 25% нь шаардлагатай, гэсэн бол 10% нь огт шаардлагагүй гэж үзжээ /График 11/.

Таны бодлоор хүмүүс мансууруулах бодисыг хэрэглэдэг шалтгаан юу вэ?



Судалгаанд оролцогчдын 21% нь хүмүүс мансууруулах бодисыг бусдын дарамт шахалтаар хэрэглэдэг, 25% нь сонирхоод хэрэглэдэг, 24% нь бусдыг дуурайж хэрэглэдэг гэсэн бол 25% нь тайвширах гэж хэрэглэдэг гэж хариулжээ /График 12/.



Судалгаанд оролцогчдын 54% нь мансууруулах бодисын хор уршигийн талаар бага зэрэг мэднэ, 39% нь маш сайн мэднэ гэсэн бол 7% нь огт мэдэхгүй гэсэн байна /График 13/.




График 14

Энэ асуултад архи, утаат тамхи, газ, цавуу, өвс, кокайн, марихуан зэрэг мансууруулах бодисын төрлүүд өндөр үзүүлэлттэй байна. Мөн ахлах ангийн сурагчдын хувьд газ, цавуу, будаг, бензин, кокайн, мөс, марихуан, хар тамхи гэсэн хариулт давамгайлж байгаа бол дунд ангийн сурагчдын хувьд архи, тамхи гэсэн хариулт давамгайлж байна /График 14/. Дээрх асуултанд сурагчид давхардсан 352 хариулт өгсөн байна.




График 15

Дээрх графикаас үзэхэд ахлах ангийн сурагчдын хувьд сэтгэгцэд нөлөөлнө, эрүүл мэндэд муу, үхэх аюултай, мансууруулна гэх мэт хариултууд нь давамгайлж байгаа бол, дунд ангийн сурагчдын дунд мөн эрүүл мэндэд муу, мансуурна, үхэх аюултай гэх мэт хариултууд нь давамгайлж байна /График 15/. Дээрх асуултанд сурагчид давхардсан 340 хариулт өгсөн байна.

Орон нутаг, нийслэлийн харьцуулсан ахлах ангийн судалгаа

Хүснэгт 1

Та мансууруулах бодисын ямар ямар төрөл мэдэх вэ? /дунд анги/				
	Хариулт	Орон нутаг	Нийслэл	Нийт
1	Архи тамхи	24	129	153
2	Хар тамхи	18	117	135
3	Өвс, иш, навч	4	27	31
4	Гааз, цавуу, будаг, бензин	18	134	152
5	Эм тариа	1	3	4
6	Элс		9	9
7	Мариухан	5	19	24
8	Кокайн	5	31	36
9	Геройн	-	1	1
10	Никотин	-	4	4
11	Ice	3	10	13
12	Мойро моёр	-	-	0
13	Жоныдан, жойн	-	-	0
14	Weed	1	-	1
15	Зэрлэг олс	-	7	7
16	Ехтасу	-	-	0
17	Нунтаг цагаан	1	9	10
18	Хариулаагүй	10	41	51
19	Мэдэхгүй	10	25	35
20	Химийн бодис	2	-	2
21	Зай	2	-	2

Та мансууруулах бодисын ямар ямар төрөл мэдэх вэ? /ахлах анги, хүснэгт 2/

Уг асуултанд 235 сурагч ямар нэг хариулт өгөөгүй байна.

	Хариулт	Орон нутаг	Нийслэл	нийт
1	Архи тамхи	29	112	141
2	Хар тамхи	29	143	172
3	Өвс, иш, навч	9	53	62
4	Гааз, цавуу, будаг, бензин	45	179	224
5	Эм тариа	6	30	36
6	Элс	-	11	11
7	Мариухан	14	23	37
8	Кокайн	17	35	52
9	Геройн	2	6	8
10	Никитон	-	36	36
11	Ice	6	29	35
12	Мойро моёр	-	2	2

13	Жоныдан, жойн	-	2	2
----	---------------	---	---	---

Та мансууруулах бодисын хор уршигийн талаар юу мэдэх вэ? /ахлах анги, хүснэгт 3/ Уг асуултанд 131 сурагч ямар нэг хариулт өгөөгүй байна.				
		Орон нутаг	Нийслэл	Нийт
1	Оюун ухаанаа алдах	15	39	54
2	Галзуурах	-	13	13
3	Үхэх аюултай	17	81	98
4	Мэдрэлийн эс үхнэ	-	7	7
5	Хариулаагүй	8	27	35
6	Сэтгэцэд нөлөөлнө	14	102	116
7	Эрүүл мэндэд муу	37	98	135
8	Гэмт хэрэгт өртөнө	5	89	94
9	Донтдог	18	103	121
10	Мансууруулдаг	16	97	113
11	Шоронд орох магадлалтай	-	11	11
12	Амиа хорлох	1	9	10
13	Мэдэхгүй	4	-	4
14	Weed	2	12	14
15	Зэрлэг олс	-	17	17
16	Ехтасу	-	7	7
17	Нунтаг цагаан	7	17	24
18	хариулаагүй	16	25	41
19	мэдэхгүй	11	19	30
20	Химийн бодис	-	-	0
21	Зай	6	-	6

Та мансууруулах бодисын хор уршигийн талаар юу мэдэх вэ?  
/дунд анги, хүснэгт 4/

Та мансууруулах бодисын хор уршигийн талаар юу мэдэх вэ? /дунд анги/ Уг асуултанд сурагчид 116 давхардсан хариулт өгсөн байна.				
		Орон нутаг	Нийслэл	Ахлах анги
1	Оюун ухаанаа алдах	12	25	37
2	Галзуурах	-	9	9
3	Үхэх аюултай	8	53	61
4	Мэдрэлийн эс үхнэ	-	9	9
5	Хариулаагүй	11	24	35
6	Сэтгэцэд нөлөөлнө	10	78	88
7	Эрүүл мэндэд муу	37	75	112
8	Гэмт хэрэгт өртөнө	1	43	44
9	Донтдог	13	65	78
10	Мансууруулдаг	13	72	85
11	Шоронд орох магадлалтай	-	13	13
12	Амиа хорлох	6	2	8
13	Мэдэхгүй	17	-	17

### 1.1.4 Нийслэл орон нутгаар харьцуулсан судалгааны үр дүн




График 16

Судалгаанд Улаанбаатар хотоос нийт 607 хүүхэд, хөдөө орон нутгаас 460 сурагчид оролцоноос нийслэлд эрэгтэй 286, эмэгтэй 321 сурагч. Хөдөө орон нутагт эрэгтэй 242, эмэгтэй 217 сурагч байна /График 16/.




График 17

Мансууруулах бодисын талаар сонсож байсан эсэх нь хөдөө орон нутгаас нийслэлд илүү байгаа нь харагдаж байна. Маш их сонсож байсан нь нийслэлд 99 байгаа бол хөдөө орон нутагт 79, ер нь сонсдог нь хөдөө орон нутагт 174, нийслэлд 222, заримдаа гэдэг нь нийслэлд 265, хөдөө орон нутагт 194, огт сонсоогүй нь нийслэлд 28, хөдөө орон нутагт 12 байна /График 17/. Уг асуултанд сурагчид 6 давхардсан хариулт өгсөн байна.




График 18

Мансууруулах бодисын талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ гэсэн асуултанд нь нийслэлд судалгаанд оролцогчдын хамгийн их буюу 250 нь интернэтээс авсан, хөдөө орон нутагт судалгаанд оролцогчдын хамгийн их буюу 162 нь телевиз, кинон дээрээс мэдээлэл авдаг. Мэдээлэл аваагүй нь хөдөө орон нутагт 9 буюу нийслэлд 19 тус тус байна /График 18/. Уг асуултанд сурагчид 152 давхардсан хариулт өгсөн байна.




График 19

Уг асуултад 16 сурагч ямар нэг хариулт өгөөгүй байна.




График 20

Мансууруулах бодисын төрлийг мэдэх үү гэсэн асуултад нийслэлд судалгаанд оролцогчдын 245, орон нутагт судалгаанд оролцогчдын 200 хүн нь 1-3 төрөл мэддэг гэх хариулт өгсөн нь анхаарал татаж байна /График 20/. Уг асуултад 220 сурагч ямар нэг хариулт өгөөгүй байна.




График 21

Орон нутагт олон хүн харсан тохиолдол 178, нийслэлд 179, 3-5 хүн харсан тохиолдол нийслэлийн хувьд 58, орон нутгийн хувьд 33, 1-2 хүн харсан тохиолдол нийслэлийн хувьд 131, орон нутгийн хувьд 102 байгаа бол огт хараагүй тохиолдол нийслэлийн хувьд 158, орон нутгийн хувьд 143 байна. Энэ нь орон нутаг нийслэлийн аль алинд нь мансууруулах бодис хэрэглэсэн олон хүн харсан гэсэн тохиолдол өндөр байна /График 21/. Уг асуултад 85 сурагч ямар нэг хариулт өгөөгүй байна.




График 22



Мансууруулах бодисыг сонирхох маягаар хэрэглэж үзэж байсан уу? гэсэн асуултанд огт хэрэглэж байгаагүй гэсэн үзүүлэлт нь хамгийн өндөр нийслэлд 389, хөдөө орон нутагт 362 байна. Олон удаа хэрэглэсэн гэсэн үзүүлэлт нь нийслэлд 41, хөдөө орон нутагт 9 байна. Хааяа хэрэглэдэг гэсэн үзүүлэлт нь нийслэлтэй харицуулвал хөдөө орон нутагт 5-аар илүү буюу 15 байна. Ганц удаа хэрэглэж байсан гэсэн үзүүлэлт нь нийслэлд 62, хөдөө орон нутагт 64 байна /График 22/, 115 сурагч энэ асуултанд ямар нэг хариулт өгөөгүй байна.




График 23

Мансууруулах бодисын талаарх мэдээллийг интернет, телевизээр авдаг нь хамгийн өндөр үзүүлэлттэй гарсан байна. Нийслэлд 168 буюу хөдөө орон нутагт 137 байна. Дараагийн өндөр үзүүлэлт нь хичээл, сургалтаар мэдээлэл авдаг нь нийслэлд 160, хөдөө орон нутагт 126 байна. Үлдсэн хувь нь хүрээлэн буй хүмүүс найз нөхдөөсөө мэдээлэл авдаг мөн хувиараа судалсан байна. Энэ талаар мэдэхгүй гэж хариулсан нийслэлд 136, хөдөө орон нутагт 85 байна /График 23/. Уг асуултад сурагчид 10 давхардсан хариулт өгсөн байна.




График 24

Хэн нэгэн мансууруулах бодисын хор уршигийн талаар танд хэлж хол байхыг сануулж байсан уу? гэсэн асуултанд маш их зөвлөдөг гэх хариултыг нийслэлд 188 буюу хамгийн өндөр, хөдөө орон нутагт 177 буюу хамгийн өндөр байна. Огт зөвлөж байгаагүй нь нийслэлд 76, хөдөө орон нутагт 56 байна /График 24/. Уг асуултад 95 сурагч ямар нэг хариулт өгөөгүй байна.




График 25

Танай үеийнхэнд мансууруулах бодисын хор хөнөөлийн талаар хичээл, сургалт явуулах хэрэгцээ шаардлага бий юу? гэсэн асуултанд ер нь шаардлагатай гэсэн нь нийслэлд 178, хөдөө орон нутагт 167 байна. Маш их шаардлагатай нь нийслэлд 113, хөдөө орон нутагт 110,

шаардлагатай нь нийслэлд 166, хөдөө орон нутагт 127, огт шаардлагагүй гэж хариулсан нь нийслэлд 72, хөдөө орон нутагт 44 байна /График 25/. Уг асуултад 9 сурагч ямар нэг хариулт өгөөгүй байна.




График 26

Мансууруулах бодисыг ямар шалтгааны улмаас хэрэглэдэг вэ? гэсэн асуултанд хамгийн өндөр хувьтай байгаа нь сонирхоод гэсэн хариулт нь нийслэлд 196, хөдөө орон нутагт 116 байна. Бусдыг дуурайж хэрэглэдэг гэсэн хариулт нь нийслэлд 158, хөдөө орон нутагт 120 байна. Бусдын дарамт шахалтаар гэсэн хариулт нь нийслэлд 65, хөдөө орон нутагт 57 байна. Тайвшрах гэж хариулсан хариулт нь нийслэлд 153, хөдөө орон нутагт 120 байна /График 26/. Уг асуултад сурагчид 5 давхардсан хариулт өгсөн байна.




График 27

Мансууруулах бодисын хор уршгийн талаар мэдэх үү? гэсэн асуултанд бага зэрэг гэсэн хариулт нь хамгийн өндөр байгаа нь нийслэлд 322, хөдөө орон нутагт 227 байна. Маш сайн мэдэх нь нийслэлд 150, хөдөө орон нутагт 94, огт мэдэхгүй нь нийслэлд 43, орон нутагт 33 байна /График 27/. Уг асуултад 198 сурагч ямар нэг хариулт өгөөгүй байна.

### 1.1.5 Ахлах, дунд ангийн сурагчдаар харьцуулсан судалгааны дүн




График 28

Ахлах ангийн нийт сурагчдаас эрэгтэй нь 299, эмэгтэй нь 314. Дунд ангийн нийт сурагчдаас эрэгтэй нь 229 эмэгтэй нь 224 байна /График 28/.




График 29

Мансууруулах бодисын талаар сонсож байсан уу? гэсэн асуултанд ахлах ангийн сурагчдын хувьд ер нь сонсдог гэсэн үзүүлэлт өндөр байгаа бол дунд ангийнхны хувьд заримдаа гэдэг хариулт нь илүү өндөр үзүүлэлттэй гарсан байна. Үүнээс үзэхэд мансууруулах бодисын талаар ахлах анги болон дунд ангийнхан аль аль нь сонссон байна /График 29/. Уг асуултад сурагчид 6 давхардсан хариулт өгсөн байна.




График 30

Мансууруулах бодисын талаарх мэдээллийг хаанаас авсан бэ? гэсэн асуултанд найз нөхөд гэсэн хариулт ахлах анги 77, дунд анги 42 байна. Гэр бүл хамаатан садан гэсэн хариулт ахлах анги 52, дунд анги 43 байна. Сонин сэтгүүл гэсэн асуултанд ахлах анги 115, дунд анги 87 байна. Телевиз гэсэн хариулт ахлах анги 189, дунд анги 180 байна. Интернэт гэсэн хариулт ахлах анги 221, дунд анги 144 байна. Мэдээлэл аваагүй гэсэн асуултанд ахлах анги 7, дунд анги 21 байна. Бусад гэсэн хариулт ахлах анги 25, дунд анги 16 байна /График 30/. Уг асуултад сурагчид 152 давхардсан хариулт өгсөн байна.




График 31

Хүүхэд, өсвөр үеийнхний дунд энэ төрлийн бодисын хэрэглээ ямар түвшинд байдаг гэж үзэж байна вэ? гэсэн асуултанд маш түгээмэл гэсэн асуултанд ахлах анги 60, дунд анги 50 байна. Түгээмэл гэсэн гэсэн хариулт ахлах анги 258, дунд анги 196 байна. Түгээмэл бус гэсэн хариулт ахлах анги 44, дунд анги 22 байна. Бага гэсэн хариулт ахлах анги 92, дунд анги 52 байна. Маш бага гэсэн хариулт ахлах анги 42, дунд анги 29 байна. Мэдэхгүй гэсэн хариулт ахлах анги 99, дунд анги 107 байна /График 31/. Уг асуултад 16 сурагч ямар нэг хариулт өгөөгүй байна.




График 32

Мансууруулах бодисын хэдэн төрөл мэдэх вэ? гэсэн асуултанд 8 болон түүнээс дээш гэсэн хариулт ахлах ангийн хувьд 26, дунд ангийн хувьд 16 байна. 5-8 төрөл гэсэн хариулт ахлах ангийн хувьд 34, дунд ангийн хувьд 23 байна. 3-5 төрөл гэсэн хариулт ахлах ангийн хувьд 164, дунд ангийн хувьд 70 байна. 1-3 төрөл гэсэн хариулт ахлах ангийн хувьд 249, дунд ангийн хувьд 212 байна. Огт мэдэхгүй гэсэн хариулт ахлах ангийн хувьд 81, дунд ангийн хувьд 129 байна /График 32/. Уг асуултад 63 сурагч ямар нэг хариулт өгөөгүй байна.




График 33

Мансууруулах бодис хэрэглэсэн хүн харж байсан уу? гэсэн асуултанд олон хүн харсан гэсэн хариулт ахлах ангийн хувьд 214 , дунд ангийн хувьд 143 байна. 3-5 хүн харж байсан нь ахлах ангийн хувьд 36, дунд ангийн хувьд 55 байна. 1-2 хүн харж байсан гэсэн хариулт ахлах ангийн хувьд 150, дунд ангийн хувьд 83 байна. Огт харж байгаагүй гэсэн хариулт ахлах ангийн хувьд 162, дунд ангид 139 байна /График 33/. Уг асуултад 85 сурагч ямар нэг хариулт өгөөгүй байна.




График 34

Мансууруулах бодисыг сонирхох маягаар хэрэглэж үзэж байсан уу? гэсэн асуултанд огт хэрэглэж байгаагүй гэсэн хариулт ахлах ангийн хувьд сурагчид 436 , дунд ангийн хувьд 315 байна. Ганц удаа хэрэглэж байсан гэсэн хариулт ахлах ангийн хувьд 85 , дунд ангийн хувьд 43 байна. Хааяа хэрэглэдэг гэсэн хариулт ахлах ангийнхны хувьд 14, дунд ангийнхны хувьд 11 байна. Олон удаа хэрэглэсэн гэсэн хариулт ахлах ангийн хувьд 16, дунд ангийн хувьд 34 байна /График 34/. Уг асуултад 115 сурагч ямар нэг хариулт өгөөгүй байна.




График 35

Сургалтанд хамрагдаж байсан уу? гэсэн асуултанд хичээлээр судалсан гэсэн хариулт ахлах ангийн хувьд 175, дунд ангийн хувьд 111 байна. Хувиараа судалсан гэсэн хариулт ахлах ангийн хувьд 41, дунд ангийн хувьд 28 байна. Хүрээлэн буй хүмүүсээс гэсэн хариулт ахлах ангийн хувьд 73, дунд ангийн хувьд 38 байна. Интернэт зурагт, радио гэсэн хариулт ахлах ангийн хувьд 187, дунд ангийн хувьд 118 байна. Энэ талаар мэдэхгүй гэсэн хариулт ахлах ангийн хувьд 127, дунд ангийн хувьд 94 байна. Бусад гэсэн хариулт ахлах ангийн хувьд 27, дунд ангийн хувьд 15 байна. Уг асуултад 33 сурагч ямар нэг хариулт өгөөгүй байна.




График 36

Мансууруулах бодисын хор уршгийн талаар танд хэлж хол байх тухай зөвлөж байсан уу? гэсэн асуултанд маш их зөвлөдөг гэсэн хариулт ахлах ангийн сурагчидын хувьд 218, дунд ангийн сурагчдын хувьд 147 байна. Хааяа зөвлөдөг гэсэн хариулт ахлах ангийн хувьд 168, дунд ангийн хувьд 118 байна. Ганц хоёр удаа зөвлөж байсан нь ахлах ангийн хувьд 114, дунд ангийн хувьд 75 байна. Огт зөвлөж байгаагүй нь ахлах ангийн хувьд 59, дунд ангийн хувьд 73 байна /График 36/. Уг асуултад 95 сурагч ямар нэг хариулт өгөөгүй байна.




График 37

Танай үеийнхэнд мансууруулах бодисын хор хөнөөлийн талаар хичээл, сургалт явуулах хэрэгцээ шаардлага бий юу? гэсэн асуултанд маш их шаардлагатай гэсэн нь ахлах ангийн хувьд 127, дунд ангийн хувьд 96 байна. Ер нь шаардлагатай гэсэн нь ахлах ангийн хувьд 217, дунд ангийн хувьд 128 байна. Шаардлагатай гэж хариулсан нь ахлах ангийн хувьд 155, дунд ангийн хувьд 136 байна. Огт шаардлагагүй гэсэн нь ахлах ангийн хувьд 55, дунд ангийн хувьд 61 байна /График 37/. Уг асуултад 92 сурагч ямар нэг хариулт өгөөгүй байна.





График 38

Хүмүүс мансууруулах бодисыг ямар шалтгааны улмаас хэрэглэдэг вэ? гэсэн асуултанд бусдын дарамт шахалтаар гэсэн нь ахлах ангийн хувьд 63, дунд ангийн хувьд 59 байна. Тайвшрах гэсэн нь ахлах ангийн хувьд 189, дунд ангийн хувьд 99 байна. Бусдыг дуурайж гэсэн нь ахлах ангийн хувьд 155, дунд ангийнхны хувьд 123 байна. Сонирхоод гэсэн хариулт нь ахлах ангийн хувьд 160, дунд ангийн хувьд 152 байна. Бусад гэсэн хариулт өгсөн нь ахлах ангийн хувьд 27, дунд ангийн хувьд 45 байна /График 38/. Уг асуултад сурагчид 5 давхардсан хариулт өгсөн байна.



Мансууруулах бодисын хор уршгийн талаар мэдэх үү? гэсэн асуултанд маш сайн гэсэн нь ахлах ангийн хувьд 163 , дунд ангийнхны хувьд 81 байна. Бага зэрэг гэсэн нь ахлах ангийнхны хувьд 299 , дунд ангийнхны хувьд 250 байна. Огт мэдэхгүй гэсэн нь ахлах ангийн хувьд 27, дунд ангийнхны хувьд 49 байна /График 39/. Уг асуултад 198 сурагч ямар нэг хариулт өгөөгүй байна.

### 1.1.6 Ярилцлагын дүн

Ярилцлагад нийслэл, орон нутгийн нийт 20 сурагчид оролцсоноос эрэгтэй 13, эмэгтэй 8 байна.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын талаар юу мэдэх вэ гэсэн асуултанд ярилцлагад оролцсон нийт сурагчид мансууруулж ухаан алддаг, донтдог. Кокаин, мөс, гааз, никотин, вийд, нунтаг цагаан, марихуан, каннабис, цавуу гэж сонсож байсан гэж хариулсан.

Энэ төрлийн бодис , ургамал хэрэглэдэг хүнийг таних уу гэсэн асуултад 3-4 сурагч гааз үнэртэх, өвс татахыг харж байсан үлдсэн нь харж байгаагүй гэжээ.

Энэ төрлийн бодисонд хүүхдүүдийн автаж буй шалтгааныг юу гэж боддог вэ гэсэн асуултад сонирхоод л хэрэглэдэг гэсэн нь илүү байсан ба бусдыг дуурайж хэрэглэдэг, тайвшрах гэж хэрэглэдэг гэж хариулсан байна. Үүнээс гадна гэр бүлийнхэнтэйгээ муудалцсан үедээ, сэтгэл санаагаар унасан үедээ хэрэглэдэг гэсэн хариулт түгээмэл байна.

Энэ төрлийн бодисоос урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтанд хамрагдаж байсан уу гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 10 нь хэдэн жилийн өмнө л хамрагдаж байсан сайн санахгүй байна гэж хариулсан бол 3 нь хамрагдаж байсан гэж хариулсан байна.

Хор уршиг, хохирлын талаар мэдээллийг хаанаас, хэрхэн олж авдаг вэ гэсэн асуултад интернет, зурагтаар энэхүү мэдээллийг авдаг гэсэн хариулт нийтлэг байна.

Үүнийг хэрэглэсний сул талыг юу гэж бодож байна вэ гэсэн асуултад биед хортой, сэтгэцэд нөлөөлдөг, мансуурдаг, донтдог гарч чаддаггүй гэж хариулсан байна.

Энэ төрлийн бодисыг хэрэглэх, түүнд автах эрсдэл бүхий нөхцөл байдалд түүнээс урьдчилан сэргийлэх, хол хөндий байхын тулд та яах вэ гэсэн асуултад найз нөхдөө зөв сонгох хэрэгтэй, өөрийгөө зөв удирдаж явах, өөрөө хэрэглэхгүй байх, хэрэглэдэг хүмүүсээс хол байх, зарж байгаа хүмүүсийг барих гэсэн хариултыг өгсөн бол нэг сурагч найзууд нь хэрэглэж байхад хажууд нь өөр юм хийгээд байж байдаг гэж хариулсан байна.

Үүний хор уршигийг танилцуулахын тулд хэн, ямар үйл ажиллагаа хэрэгжүүлбэл илүү үр дүнтэй болох вэ гэсэн асуултад энэ төрлийн сургалтыг сонирхолтой байдлаар явуулах, хаана ургадаг эсэхийг нууцлах, эвгүйцэж жихүүцмээр бичлэг үзүүлэх мөн хүүхдүүдийг тийм юманд өртөхгүй байхаас сэргийлж сургууль дээр үнэ төлбөргүй дугуйлан хичээллүүлэх, зардаг хүмүүсийг баривчлах, бүх өвсийг устгалд оруулах хэрэгтэй гэж хариулсан байна.

#### Онцлох тэмдэглэл:

Сэлэнгэ аймгийн 12 дугаар ангийн сурагчийн нэмэлт ярилцлагын тэмдэглэлээс: (эрэгтэй) Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумаас 9 км зайд ургадаг. Хүмүүс түүж аваад кг нь 12000-аар зардаг. Сумын төвөөс хол цагдаа байдаггүй учраас хүмүүс түүж зарах нь элбэг байдаг. Хатаасан өвс нь илүү үнэтэй байдаг. Мөн үндсээр нь авч зардаг.

Орхон аймгийн 10 дугаар ангийн сурагчийн яриа: (эрэгтэй) Нэг удаа өвс хэрэглэж үзсэн. Найзынхаа гэрт найзуудтайгаа хамт хэрэглэсэн. Дахиж хэрэглэхгүй гэж бодсон. Маш муухай юм байна лээ.

Баянгол дүүргийн 28 дугаар сургуулийн 11 дүгээр ангийн сурагч: (эмэгтэй) Нэг удаа өвс татаж үзсэн. Хэрэглэхэд толгой эргээд манарсан. Яг тэр үеийн юмаа санадаггүй, мөнгөлөг цаас, болон ундааны сав ашиглаж сордог юм байна лээ.

Чингэлтэй дүүргийн 50 дугаар сургуулийн 11 дүгээр ангийн сурагч: (эрэгтэй) Нэг удаа сонирхоод газ үнэрлэж үзсэн.

Эдгээрээс дүгнэж үзэхэд ярилцлаганд оролцсон сурагчдаас нийслэлийн сурагчид орон нутгийнхнаас илүү их мэдээлэлтэй байсан ба өөрсдөө хэрэглэж үзсэн тохиолдол ч байсан. Харин хөдөө орон нутгийн хувьд ургадаг гэж сонсож байснаас хэрэглэж байсан, харж байсан хүүхэд байгаагүй. Хөдөө орон нутгийг бодвол нийслэлийн сурагчдын дотор мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын талаарх мэдээлэл их байна.

### 1.1.7 Судалгаагаар тогтоогдсон нөхцөл байдал

Судалгаанд Улаанбаатар хотын 5 дүүрэг, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ аймгуудын нийт 1067 сурагчид оролцсон. Нийт оролцогчдын 529 нь эрэгтэй, 538 нь эмэгтэй сурагч байна. Үүнээс 7 дугаар ангийн 60, 8 дугаар ангийн 157, 9 дүгээр ангийн 215, 10 дугаар ангийн 243, 11 дүгээр ангийн 189, 12 дугаар ангийн 203 хүүхэд оролцсон.

Оролцогчдын 37% нь мансууруулах бодисын талаар ер нь сонсдог, 41% нь заримдаа сонсдог, 18% нь байнга сонсдог гэсэн бол 4% нь огт сонсоогүй гэсэн байна. Үүнээс үзэхэд сурагчдын 96% нь уг бодисын талаар ямар нэг хэмжээгээр мэдээлэлтэй байна. Сурагчдын 28% нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын тухай мэдээллийг телевиз, киноноос, 27% нь интернет, 15% нь сонин сэтгүүл, 10% нь гэр бүл хамаатан садан, 12% нь найз нөхдөөсөө мэдээлэл авсан гэсэн бол 4% нь энэ талаарх мэдээлэл огт аваагүй гэсэн байна. Үүнээс үзэхэд энэхүү бодисын талаарх мэдээллийг интернет, телевиз, киноноос авах нь түгээмэл байна.

Хэдийгээр дунд сургуулийн сургалтын хөтөлбөрт “Эрүүл мэнд” гэдэг хичээл бие даасан судлагдахуун болж 2004-2015 оны хооронд заагдаж, түүнд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, үр дагавар, зайлсхийх аргыг заадаг байсан ч хүүхдүүд энэ талаар мэдээлэл, мэдлэг хомс байгаа нь сургалтын агуулга, хөтөлбөрт өөрчлөлт оруулах, багш нарын заах арга барилыг өөрчилж мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын талаарх мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, тусгайлан бэлтгэх шаардлагатайг харуулж байна.

Судалгаанд оролцогчдын 44% нь уг бодисын 1-3 төрөл мэднэ, 21% нь 3-5 төрөл мэднэ, 20% нь огт мэдэхгүй, 5% нь 5-8 төрөл мэднэ гэсэн бол 10% нь 8-аас дээш төрөл мэднэ гэсэн ба 41% нь мансууруулах бодисын хэрэглээ өсвөр үеийнхний дунд түгээмэл байдаг, 15% нь маш түгээмэл, 20% нь мэдэхгүй, 13% нь бага, 5% нь маш бага, 6% нь түгээмэл бус байдаг гэж үзжээ. Үүнээс үзэхэд өсвөр насныхны дунд мансууруулах бодисын талаарх мэдээлэл түгээмэл байдаг нь харагдаж байна.

Сурагчдын 321 нь мансууруулах бодис хэрэглэсэн хүн огт хараагүй, 240 нь 1-2 хүн харсан, 73 нь 3-5 хүн харсан гэсэн бол 449 нь мансууруулах бодис хэрэглэсэн олон хүн харсан гэсэн байна. Үүнээс үзэхэд мансууруулах бодис хэрэглэсэн хүнийг харсан нь илүү их байгаа нь харагдаж байна.

Сурагчдын 74% нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис огт хэрэглэж байгаагүй, 13% нь ганц удаа хэрэглэж байсан, 2% нь хааяа хэрэглэдэг гэсэн бол 11% нь олон удаа хэрэглэж байсан гэсэн байна. Үүнээс үзэхэд өсвөр насныхны дунд мансууруулах бодисын хэрэглээ байсаар байна.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээнээс хол, хөндий байх талаар хэн нэгэн танд зөвлөдөг үү гэсэн асуултад сурагчдын 46% нь маш их зөвлөдөг, 25% нь хааяа зөвлөдөг, 17% нь ганц хоёр удаа л зөвлөж байсан гэсэн бол 12% нь огт зөвлөж байгаагүй гэсэн байна. Мөн тэдний 28% нь мансууруулах бодисын хор уршиг, урьдчилан сэргийлэх талаар интернетээс үзсэн, 31% нь хичээлээр судалсан, 19% нь энэ талаар мэдэхгүй, 14% нь найз нөхөд, хүрээлэн буй хүмүүсээс судалсан бол 6% нь хувиараа судалсан байна.

Судалгаанд оролцогчдын 26% нь уг бодисыг нэг ба түүнээс дээш удаа хэрэглэсэн үзүүлэлт байгаа нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ өсвөр үеийнхний дунд тодорхой хэмжээнд байгаа нь харагдаж байна. Мөн сурагчдын 70% нь хэвлэл мэдээлэл, интернет телевиз, сонин сэтгүүлээс энэ төрлийн бодисын тухай мэдээллийг авч байгаа нь хэвлэл мэдээллийн сувгуудын хөтөлбөр хүүхдийн хүмүүжил төлөвшилд нөлөөлөх төдийгүй хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирохгүй байж болох юм. Цаашлаад эцэг, эхчүүдийн хүүхдийнхээ цахим хэрэгслийн хэрэглээнд тавих хяналт сул, хүүхдүүд чөлөөт цаг заваа зурагт ширтэж эсвэл олон нийтийн сүлжээнд хамрагдаж, үр бүтээлгүй өнгөрөөж байна. Тиймээс хүүхдийг чөлөөт цаг заваа зөв боловсон өнгөрөөх боломжоор хангах нь хүүхдийг гэмт хэрэгт өртөх эрсдлээс хамгаалах, мансууруулах бодис хэрэглэх, үеийнхэнтэйгээ нийлж дарвихаас сэргийлэхэд чухал нөлөөтэй.

Нийслэл болон орон нутгаар харьцуулан үзэхэд нийслэлийн хувьд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ нь орон нутгаас өндөр үзүүлэлттэй байна. Нийслэл, орон нутгийн аль алинд нь уг бодисын мэдээллийг интернетээс авдаг нь өндөр үзүүлэлттэй гарсан ба нийслэл, орон нутгийн аль алинд нь хэрэглээний түвшин ахлах ангийнхны дунд тодорхой хэмжээнд байгаа нь анхаарал татаж байна.

Ахлах болон дунд ангиар харьцуулахад, дунд ангийн сурагчдын хувьд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг архи, тамхи гэж үзэж байгаа бол ахлах ангийнхны хувьд хар тамхи гэж



ойлгож байгаа бөгөөд тэдний хэрэглээний түвшин илүү байна. Дунд ангийн сурагчдын хувьд хэрэглээ харьцангуй бага хэдий ч уг бодисын тухай мэдээлэл их байгаа нь хүүхдийн энэ төрлийн бодист автах эрсдэлтэй гэж үзлээ.

Ярилцлагад оролцсон сурагчдын 4 нь хэрэглэж үзсэн харин 3 нь найзууд нь хэрэглэж байхад хажууд нь хамт байсан гэсэн нь сурагчид мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэх эрсдэл өндөр байгааг нотолж байна.

Сурагчдын дунд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ нэмэгдэх эрсдэл ажиглагдаж байна. Энэ нь хамтран суралцагч болон цахим сүлжээгээр дамжин хүрээгээ тэлэх хандлагатай байна.

Иймд хүүхэд залуучуудыг энэ төрлийн бодис, эм бэлдмэлийн нөлөөлөл, зүй бус сурталчилгаанаас ангид байлгах, дунд сургуулийн хичээлийн хөтөлбөрт холбогдох өөрчлөлтийг оруулах, сургууль, найз нөхөд, оршин суух болон цэнгээний газрын орчинд хууль сахиулах байгууллагын хяналтыг чиглүүлэх хэрэгцээ шаардлага бий болжээ.

## 1.2 Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэгчд /ялтнуудаас/-ийн дунд зохион байгуулсан санал асуулга, ярилцлага

### 1.2.1 Мэдээллийн эх үүсвэр ба мэдээлэл цуглуулсан аргууд

Энэхүү судалгааг нэгэн агшины, олон шатлалт түүвэрлэлттэй, тоон судалгааны аргаар хийсэн. Судалгаанд нийт 30 мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэгчдээс /ялтнуудаас/ тусгайлан бэлтгэсэн асуумж авч, нэгэн агшинд хийгдсэн болно. Судалгааны асуумж нь дараах бүтэцтэй. Үүнд:

1. Судалгаанд оролцогсдын ерөнхий мэдээлэл (нас, хүйс, боловсрол)
2. Судалгаанд оролцогсдын хэрэглээний байдал
3. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын талаархи мэдлэг, хандлага, дадал
4. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг гэсэн 4 чиглэлээр нийт 14 асуултаар мэдээлэл цуглуулсан болно.

Судалгааны арга, хэрэглэгдэхүүнийг боловсруулсаны дараа мэдээлэл хэрхэн цуглуулах сургалтыг судлаачид, мэдээлэл цуглуулагчдыг оролцуулан зохион байгуулснаас гадна тэдгээрийг туршин үзэж, засан сайжруулав. Судалгааг 2017 оны 10-аас 11 дүгээр сарын хугацаанд Хар тамхи, мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэг-ТББ болон судалгааны IRIM төвөөс өгсөн зөвлөгөө, арга зүйн тусламжтайгаар хийсэн.

### 1.2.2 Судалгааны түүвэрлэлт

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэгчдийн дундах хэрэглээний байдал, тэдний мэдлэг, хандлага, хор уршгийн талаарх тандалт судалгаа” энэ төрлийн бодис хэрэглэгчдийн дунд хийгдэж байгаа тул түүвэрлэлтийг хийхдээ төлөөлөх чанарт үндэслэсэн болно. Судалгааны түүвэрлэлтийг хүмүүсээс дараах шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан сонгосон. Үүнд:

- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт ял шийтгэгдэж, хорих ял эдэлж буй;

- Хоригдохоосоо өмнө сүүлийн 12 сарын хугацаанд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэх.

Судалгаанд	хамрагдсан	хэрэглэгчдийн	бүтэц
	Хэн		Тоо
2017 оны 10 сард хорих ангиудаар хийсэн судалгаанд хамрагдсан ялтнууд			27
Цагдан хоригдож байгаа этгээд			3
Нийт			30

### 1.2.3 Судалгааны боловсруулалт

Тоон судалгааны мэдээллийг хянаж, шалгасны дараа хүчин төгөлдөр 30 асуумжийн хуудсыг SPSS-20 программыг ашиглан мэдээллийн бааз үүсгэн, мэдээлэл шивэх, шивэлтийн алдааг хянах үйлдлүүдийг гүйцэтгэсэн ба уг программаар үр дүнгийн тооцооллыг үзүүлэлтүүдийн хүрээнд боловсрууллаа. Судалгааны үр дүнг тооцоолохдоо нас, хүйс, боловсрол, байршил, гэр бүлийн байдал, хэрэглээний байдлыг үндсэн үзүүлэлт болгон авсан. Үр дүнг нэг болон хоёр хүчин зүйлүүдийн хоорондын хамаарал, тархалтыг тооцоолох гэсэн үндсэн зарчмыг баримталсан болно. Судалгааны үндсэн үр дүнг хүснэгтэн төлөвлөгөөний дагуу боловсруулж судалгааны тайлан бичиглэлд ашигласан.

Товч намтар, гэр бүл, өссөн орчны тухай.

#### А. Судалгаанд хамрагдагсдын нас




График 40

#### Б. Хүйсийн байдал


Эр-27      Эм-3

#### В. Боловсролын түвшин




График 41


#### Г. Гэр бүлийн байдал *График 42*




#### Д. Та хүүхэдтэй юу? *График 43*



#### Е. Өссөн гэр бүлийн орчин *График 44 ба 45*



Ё.Хаана амьдарч, сурч байсан талаар. *График 46*



Хорих ангиудад хийсэн судалгаанд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт ял шийтгэгдсэн мөн хэрэглэдэг хэмээн бүртгэгдсэн нийт 30 хүнийг хамруулсан болно. Хэрэглэгчдийн дунд хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ, ойлголт, хор уршгийн талаархи мэдээллийг асуумж судалгааны аргаар авсан.

#### 1.2.4 Судалгаанд хамрагдагсдын ерөнхий үзүүлэлт

Судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн нийгэм хүн ам зүйн байдал: Судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн нийгэм, хүн ам зүйн байдлыг дараах хүснэгт, зургуудаар харуулав.

#### Ерөнхий мэдээлэл

<b>Нас /жилээр</b>		
<b>Насны ангилал</b>	<b>n</b>	
20-оос бага	1	
21-25	4	
25-30	6	
31-35	9	
36-40	7	
41-45	1	
46-50	1	
50 –аас дээш	1	
<b>Хүйс</b>		
Эрэгтэй	27	
Эмэгтэй	3	
<b>Яс үндэс</b>		
Халх	28	
Казак	1	
Гадаадын иргэн	1	

Гэрлэлтийн байдал		
Гэрлэсэн	20	
Салсан	2	
Гэрлэж байгаагүй	7	
Хамтран амьдардаг	1	
Хүүхэдтэй эсэх		
Хүүхэдгүй	7	
1 хүүхэдтэй	9	
2 хүүхэдтэй	10	
3 хүүхэдтэй	2	
4 хүүхэдтэй	2	

Судалгаанд нийт 15-59 насны хэрэглэгчид хамрагдсанаас 19-35 насныхан 66%-ийг эзэлж байгаа ба хэрэглэгчдийн дундаж нас 25-35 байна. Хүйсийн хувьд эрэгтэй нь 78%, эмэгтэй нь 10% ба эрэгтэйчүүдийн дунд хэрэглээ илүү байна. Нийт судалгаанд хамрагдагсдын 89% нь халх үндэстэн байна. Судалгаанд оролцогсдын 66% нь гэр бүлтэй, харин 6,6% нь салсан, гэрлэж байгаагүй ба 23,1% нь 1-4 хүүхэдтэй 23, хүүхэдгүй 7 байлаа.

#### Судалгаанд оролцогсдын боловсрол:

Судалгаанд оролцогчдын 30% нь их дээд болон тусгай мэргэжлийн боловсролтой, 55% нь бүрэн дундаас доош боловсролтой хүмүүс байна. Гэсэн хэдий ч дээд боловсролтой нь бүрэн бус болон тусгай дунд боловсролтой хүмүүсийг бодоход мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэх нь илүү байгаа нь статистик ач холбогдолтойгоор ялгаатай байна.


#### Ял шийтгэгдэхээс өмнө хаана, ямар ажил эрхэлж байсан байсан тухай

1. Хувиараа бизнес эрхэлдэг -18 хүн
2. Хувийн хэвшлийн аж ахуй,компанид -12 хүн

Ажил эрхлэлт	Тоо	Хувь
Төрийн албан хаагч	0	0
Хувийн хэвшил	12	40
Хувиараа	18	60
Оюутан	0	0
Ажилгүй	0	0
Нийт	100	100.0

Судалгаанд оролцогсод хувийн хэвшлийн байгууллагад ажилладаг ба хувиараа ажил эрхэлдэг хүмүүс байна.

Судалгаанд оролцогсдын орлогын байдал. График 47



Сүүлийн сард /хоригдохоос өмнө/ 63,8% нь орлогоороо мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис худалдаж авсан ба үүнээс: 13,2% нь 150 мян.төгрөгөөс дээш, 6% 150,001-250 мян.төг, 26% 250000-500 мян.төг, 9% 500 мянган төгрөгөөс дээш төгрөгөөр худалдаж авсан гэх бөгөөд орлогын хэмжээ нь хэрэглээнд нөлөөлөхгүй байна. Хэрэглээгээ авах мөнгөний хэмжээ харилцан адилгүй гэж хариулсан 9% ба мөнгө зарахгүйгээр найзууд дундаа хэрэглэдэг гэсэн 36,2% байгаа юм. Хэрэглэгч Б гэхэд долоо хоногтоо 800,000-1,000,000 төгрөгийг хэрэглээндээ зарцуулдаг гэсэн байна.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт ял эдэлж буй хоригдлуудтай хийсэн ганцаарчилсан ярилцлагаас...

*Ганцаарчилсан ярилцлага: 2017.11.05*

Рок болон хип хоп урлагийнхан их хэрэглэдэг. Мөсийг хэрэглэснээр мэдрэмж дээшилж, хөгжмийн нарийн нугалааг илүү мэдэрдэг. Бас тоглолтон дээр хэрэглэхэд шоунаас авах кайф нэмэгддэг. Их эрч хүчтэй болж 3-5 хоног нойр, хоолгүй явж байсан удаатай. Үйлчилгээ дуусахад гараа ч өргөх чадалгүй болсон байдаг учир дахин хэрэглэх шалтгаан болдог.

*Ганцаарчилсан ярилцлага: 2017.10.27*

2009 онд өвс буюу каннабис, гашишийн хэрэглээ давамгайлж, энэ төрлийн бодис биедээ болон орон байрандаа хадгалах, худалдах явдал их байсан бол 2017 онд бодисын төрөл, байдал өөрчлөгдөж нийлэгжүүлэн гаргаж авсан сэргээгч бодисын хэрэглээ өссөн. Өвсийг найзууд дундаа мөнгө зарахгүйгээр хэрэглэдэг байсан. Мөнгөтэй үедээ голчлон “мөс” хэрэглэдэг.

*Гэр бүл, найз нөхдийн хүрээнд дэх мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээний байдал*

График 48

Гэр бүл, найз нөхдийн хүрээнд мансууруулах болон сэтгэц идэвхит эм, бодис хэрэглэдэг хүн байдаг эсэх	Тоо	Хувь
<b>Тийм</b>	18	59,4
<b>Байхгүй</b>	10	33
<b>Мэдэхгүй</b>	2	6,6
<b>Нийт</b>	100	100.0


2009 онд өвс буюу каннабис, гашишийн хэрэглээ давамгайлж, энэ төрлийн бодис биедээ болон орон байрандаа хадгалах, худалдах нь нийтлэг байсан, 2017 онд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын төрөл, хэлбэр, чанар өөрчлөгдөж нийлэгжүүлэн гаргаж авсан сэргээгч бодисын хэрэглээ өссөн.

*Хэрэглэгчийн уг бодисыг анх хэрэглэсэн нас*

График 49

Хэрэглэж эхэлсэн нас	Тоо	Хувь
<b>10-15 насанд</b>	1	3,3
<b>16-20 насанд</b>	8	26,4
<b>21-25 насанд</b>	6	20
<b>26-30 насанд</b>	8	26
<b>31-35 насанд</b>	3	9,9
<b>36-40 насанд</b>	3	9,9
<b>41-45 насанд</b>	1	3,3
<b>46-50 насанд</b>		
<b>Нийт</b>	30	100.0

Уг бодисыг анх хэрэглэх болсон шалтгаан. *График 50*




Уг бодисыг 14-20 насанд хэрэглэж эхэлсэн нь 29,7%, 20-30 насандаа 14 хүн/46,2/ эзэлж байгаа ба үүнээс 30-40 насандаа хэрэглэсэн 6 хүн /19,8/, нийт хэрэглэгсдээс 46,2 нь анх 20-30 насандаа хэрэглэж эхэлсэн байна. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг 75% нь сонирхож буюу бусдыг дууриаж хэрэглэдэг байна. /График 46, 47/

Энэ үзүүлэлт нь түүний хор уршиг, үр дагаврын талаар судалгаанд оролцогсад анхны мэдэгдэхүүн багатай, энэ талаар мэдээлэл авсан үедээ хэрэглэж үзэх сонирхол шууд төрж байгаа буюу бусдын нөлөөлөлд автаж, даган дуурайж хэрэглэсэн зэрэг нь эрсдлийн менежмент муу, энэ талаар анхан шатны ойлголт байхгүйг илтгэнэ.

Хэрэглэдэг бодисын төрөл.

/Амьдралын туршид, сүүлийн 12 сарын хугацаанд, үүнээс сүүлийн 3 сарын хугацаанд, *График 51/*



Судалгаанд хамрагдагсадын 3,3% нь 1 төрлийн, 25% нь 1-2 төрлийн, 10% нь 3 төрлийн, 6,6% нь 4-өөс дээш төрлийн мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэдэг.


Мөн олонх нь буюу 91,5% мөс хэрэглэдгийн зэрэгцээ LSD 9,9%, бусад буюу шавар 23%, экстази 9,9%, каннабис 36,6% зонхилон хэрэглэж байна. Кетамин 3,3%, кокайн 6,6%, шидэт мөөг 3,3%, молоко 3,3%, седуксин 3,3% хэрэглэсэн байна /График 48/.

**Ганцаарчилсан ярилцлага: 2017-11-02**

Хар тамхи маш олон төрөл байдаг. Олс, өвс буюу каннабис, гашиш (өө гэж монголд нэрлэдэг) хэрэглээ давамгайлж байсан бол одоо амфитамины төрлийн бодисын хэрэглээ өссөн. Хүмүүс сүүлийн үед хэд хэдэн төрлийн бодис хэрэглэх болсон. Өвсийг янз бүрийн бодистой хольж хэрэглэдэг хэрэглэгчид ч бий. Мөс их үнэтэй учир түүнийг олж авах амар биш. Хэрэглэгчдийн хүрээнд олж авахад хялбар, мөнгө байвал шууд олно.

- ✓ 1 төрлийн бодис хэрэглэдэг 1
- ✓ 1-2 төрлийн бодис хэрэглэдэг 8
- ✓ 3 төрлийн бодис хэрэглэдэг 3
- ✓ 4-6 төрлийг хэрэглэдэг 1

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэж буй аргууд. *График 52*




Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэгчдийн 33% татдаг, 85,8% сордог, 3,3% үнэрлэдэг, 3,3% нь тарьж хэрэглэдэг бол 42,9% нь эдгээр аргуудыг хослуулан татаж, сорж, үнэрлэж, тарьж хэрэглэдэг байна /График 49/.

*Ганцаарчилсан ярилцлага 2017.11.02*

... татна, сорно, хэлэн дор тавина. Нунтаг цагаан өнгөтэй бодисыг мөнгөлөг цагаан цаасан дээр шатааж үнэртдэг, бас саванд шатааж сордог. Худалдаж авсан мөсөө найзынхаа машинд хэрэглэж байгаад баригдаж, тээвэрлэсэн гэх үндэслэлээр ангиар ял авсан. Дан мөс хэрэглэдэг, өвс муухай үнэртэй учир татдаггүй, тэгээд ч үйлчилгээ нь арай сул байдаг.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис худалдан авч буй байдал



*График 53*

Судалгаанд хамрагдсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэгчдийн дийлэнх буюу 77% нь хувь хүнээс авдаг гэж хариулсан ба 2 хүн буюу 6,6% нь өөрөө түүдэг байна /График 50/.

Таны мэддэг хэдэн хэрэглэгч байдаг вэ?

*Ганцаарчилсан ярилцлага 2017.10.24*

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэдэг 100-120 хүн байгаа гэж бодож байна. Найз, найзын найзаас гэхчлэн энэ бодисыг дамжуулан олж авдаг байсан. 8 сарын сүүлээр илүү их өсдөг нийлж хэрэглэх нь ихэсдэг. Өвс олдохгүй бол мөс хэрэглэдэг, гэвч энэ их үнэтэй байдаг. Хэрэглэгчдийн тоо өсөөд байгаа нь найзуудтайгаа хааяа уулзах үед ажиглагдаж, мэдрэгдэж байсан.

### Ярилцлага 1 2017.10.31

Бээжинд явж байгаад анх хэрэглэж үзсэн. Ажлын түнш дайлж байгаад санал болгосон. Согтдоггүй, сэргээдэг гэж хэлсэн. Хэрэглэсний дараа архи шууд гарч илүү сайхан болсон 3 хоног шоудаад ирсний дараа мөсийг дахин хэрэглэмээр санагддаг болсон. Монголд ирээд сураглахад аль хэдийн сүлжээ үүссэн байсан.

... мансууруулах бодис хэрэглэгчдийг тоолоход хэцүү миний мэдэх

5—10 хүн бий ---- 3 хүн

10 ---20 хүн бий ---3 хүн

20-30 хүн байгаа --- 4 хүн

40-50 хүн байгаа ---2 хүн

80 --- 100 хүн байгаа --- 4 хүн

Барагцаагаар 100 ---150 байгаа ---3 хүн

Мэдэхгүй ----11 хүн хариулсан байна.

... Өвс, мөс, экстази хэрэглэж үзсэн. Мөсийг 350000-500000₮-өөр 1 удаагийн хэрэглээг авдаг. Өвсийг татна, үнэрлэхэд үйлчлэхгүй, сорох, утах маягаар хэрэглэдэг. Өвчин намдаах гэж, сонирхож хэрэглэдэг. Мөсийг ядрахгүй гэж хэрэглэдэг, сэргээш болдог юм.

... Дунджаар 100.000-500.000, 500.000-1.000.000 төгрөг зарцуулдаг. 7 хоногт 2-3 удаа худалдаж аваад хэрэглэдэг байсан.

### Ярилцлага авсан өдөр 2017.10.25

Миний мэдэхээр мөс хэрэглэдэг 100-150 хүн бий. Гачууртад болдог амьд хөгжмийн наадам дээр анх хэрэглэж үзсэн. Тэнд зардаг, авдаг хүмүүс бие биеэ мэддэг, өгөлцөж авалцдаг болохоор их олон залуучууд цуглардаг. Сүүлийн 6 сард хоригдсон тул уулзаагүй.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис авахад зарцуулдаг мөнгөний хэмжээ. *График 54*

Өдөрт хэд орчим төгрөг	Төгрөгөөр							Янз бүр
	Мөнгө зарцуулдаггү 100,000	150000дэ	250000	350000	500000	1000000		
Тоо	7	4	1	1	3	1	3	
Хувь	23,1	1	3,3	3,	9,9	3,	9,9	
		3,		3		3		
		2						

Хэрэглэгчдийн 67% нь өдөрт 100 000 төгрөгөөс 1 сая хүртэл төгрөгийг энэ төрлийн бодист зарцуулдаг гэсэн ба үүнээс 27% нь 100000-500000 төгрөгийг зарцуулдаг гэжээ. Харин 33% нь янз бүр байсан, мөнгө зарцуулж байгаагүй гэж хариулсан ба хэрэглэгчид мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодист 7 хоногт дунджаар 500000 төгрөгийг зарцуулдаг байна /График 51/.

### Мансууруулах, сэтгэц нөлөөлт бодисыг хэрэглэдэг газар

Хэрэглэгчдийн ихэнх нь найз нөхөд болон өөрийн гэрт /16,5%/, баар диско клубт, олон нийтийн арга хэмжээний үеэр хэрэглэдэг 13,2% нь хэрэглэдэг бол машинд 16,5% нь хаана ч хамаагүй хэрэглэдэг гэсэн нь ямар нэгэн ялгаа харагдахгүй байна.

### Судалгаанд хамрагдагсдын мэдлэг, хандлага, дадал

Мансууруулах, сэтгэц нөлөөт бодисын тухай ойлголт

*График 55*

МСНБ-ын талаар ойлголт  
байдаг уу

Тоо

Хувь



<b>Тийм</b>	30	100,0
<b>Үгүй</b>		
<b>Нийт</b>	30	100.0

Хамгийн анх мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис /хар тамхи/-ын тухай мэдээллийг хаанаас авсан талаар:

Судалгаанд хамрагдсан хэрэглэгчидийн мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын талаар ойлголттой, түүнийг найз нөхдөөсөө /33%/ эсвэл хэвлэл мэдээлэл, TV, интернетээс /27%/, бусдын яриа /3,3%/, янз бүрийн сувгаар /26,4%/ мэдээлэл авдаг байна.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис /хар тамхи/ хэрэглэснээс үүссэн үр дагаварын талаар. График 56



Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис /хар тамхи/-ын хор хөнөөлийн талаар судалгаанд оролцогсад сайн мэдэх ба мансууруулах болон сэтгэц идэвхит эм, бодис хэрэглэсний улмаас судалгаанд хамрагдагсдын дийлэнх нь хий юм харах /10%/, эцэж турах /33%/, мартамхай, ойлгохдоо удаан болох /10%/, ходоод өвдөх, хоолондоо дургүй болох /6,6%/, элэг үрэвсэж өөхлөх /6,6%/, зэрэг эмгэгт өртсөн байна. Бүгд эрх чөлөөгөө хасуулсан /График 53/.


**Ганцаарчилсан ярилцлага 2017.10. 24**

5-6 хоног хэрэглэхгүй бол толгой асар их өвдөнө, чичирнэ, бөөлжис хүрнэ, нүд бүрэлзэнэ, үхмээр санагддаг. Хэрэглэсний дараа их инээд хүрнэ, дуулмаар ч юм шиг нэг л жаргалтай, нисч байгаа юм шиг мэдрэмж төрнө, юу ч хийхэд тааламжтай зугаатай байдаг. Заримдаа хий юм харна. Жишээлбэл: зураг хөдөлж байгаа юм шиг болно, орчин солигдоно.


**Ганцаарчилсан ярилцлага 2017.10. 25**

Хор хөнөөлийн талаар ер нь мэднэ, миний хувьд каннабис хэрэглэснээс хойш тодорхой хугацааны дараа арьс хуурайших, хоолой хорсох, нулимс гоожих зэрэг таагүй үр дүн мэдэгдсэн. Цаашлаад 5 цул эрхтэнд ч нөлөөлж мэдэх ноцтой үр дагаварт хүргэхээр юм шиг санагдсан. Гэвч энэ бодисыг анх хэрэглэх үедээ энэ талаар бодож ч байгаагүй, товчхондоо юу руу орж байгаагаа ухамсарлаагүй.

Та дунд сургуулийн сурагч байхдаа энэ төрлийн бодисын хор уршиг, үр дагаварын талаар мэдлэг, боловсрол олж авч байсан уу? График 57



Таны өссөн орчин. *График 58*



### 1.2.5 Судалгаагаар тогтоогдсон нөхцөл байдал

Судалгаанд хамрагдсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой хэрэгт холбогдож ял шийтгэгдсэн болон одоо шалгагдаж буй хүмүүсийн 85% нь 35-с доош насныхан ба хоригдогчдын дундаж нас 25-30% байна. Эдгээр залуучуудын 56% нь 16-25 насандаа анх мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэж эхэлсэн нь хүүхэд, залуучуудын дунд зонхилж, цаашид буурах хандлага ажиглагдахгүй байгааг харуулна. Гол шалтгаан нь хүүхэд, өсвөр насныхныг энэ төрлийн бодисоос урьдчилан сэргийлэх тодорхой арга хэмжээ авдаггүй явдал юм.

Судалгаанд хамрагдагсдын 79,6% нь сонирхож буюу бусдыг дууриаж хэрэглэдэг нь хүмүүст энэ төрлийн бодисын хор уршгийг системтэйгээр сурталчлан таниулах мэдээлэлд дүгнэлт хийж бусдын зүй бус нөлөөнд автахгүй чадварыг олгох иргэний суурь боловсорлоор дамжсан сургалтын хөтөлбөр байхгүй буюу зохих ёсоор боловсруулагдаагүй байна.

Иймд боловсролын яамнаас баталсан бага, дунд сургуулийн боловсролын хөтөлбөрт мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаар хичээл тусгах нь зүйтэй гэж бидний хамтарсан судалгаанаас дүгнэгдэж байна.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой хэрэгт холбогдогсдын 80 хувийг эмчилгээ, соён гэгээрүүлэх ажлын тусламжтайгаар урьдчилан сэргийлэх боломжтой, харин үлдсэн 20 хувьд нь албадан эмчилгээ болон дахин гэмт хэрэг үйлдүүлэхгүй байхад чиглэсэн бусад арга хэмжээг зохион байгуулж болно.

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 93.4 хувь нь гэр бүлийн тааламжтай уур амьсгал дунд өссөн, 30 хувь нь дунджаас дээгүүр амьдралтай байгаа нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэх, түүнд автах нь гэр бүлийн хувьд өсөж төрсөн орчинтой төдийлөн хамааралгүй бөгөөд хүний эдийн засаг, санхүүгийн боломж, нийгэмд эзлэх байр сууриас үл хамаарч байна. Өөрөөр хэлбэл нийтлэг шинжтэй нийгмийн сөрөг үзэгдэл болох хандлагатай болсон байна.

Мансууруулах болон сэтгэц нөлөөт эм, бодисын хэрэглээнд ажил эрхлэлт болон орлогын хэмжээ нөлөөлөхгүй байна. Энэ нь хэрэглэгчдийн хэрэглэж байгаа бодисын төрөл болон хууль бус наймааны өөрийнх нь онцлог, хүмүүсийн орлогоо бүрэн мэдээлдэггүй зэрэгтэй холбоотой байж болзошгүй.

Үүний учир шалтгаан нь үнэ хямд, олон төрлийн синтетик бодис, бэлдмэлүүд ихээр орж ирж байгаа, түүнчлэн энэ төрлийн бэлдмэлийг гар аргаар гаргаж авах лабораториуд бий болох эрсдэлтэй байна. Хэрэглээнд хаана амьдран сууж байгаа болон гадаадад зорчсон байх нь ялгаагүй ба Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэгчдийн дийлэнх 93,4% нь хувь хүнээс авдаг, 6,6% нь өөрөө түүж бэлтгэдэг гэж хариулсанаас үзэхэд манай улсад мансууруулах сэтгэц нөлөөт эм, бодисын олдоц элбэг байна.

Судалгаанд хамрагдагсдын 33% нь 1 төрлийн, 67% нь 2-8 төрлийн мансууруулах, сэтгэц нөлөөт бодисыг татах, уух, сорох, үнэрлэх, тарих зэргээр бүхий л аргыг ашиглан хэрэглэдэг ба дийлэнх нь 71% мөс хэрэглэж байгаагийн зэрэгцээ LSD 9,9%, бусад буюу шавар 23%, экстази 9,9%, өвсийг 3,3% нь хэрэглэж байна. Энэ нь уг бодисын төрөл улам олширч байгааг илэрхийлэх үзүүлэлт юм. Эдгээр хүмүүсийн дийлэнх нь дунджаар 40 орчим хэрэглэгчийг мэддэг гэж хариулснаас үзэхэд судалгааны хүрээнд нийт хэрэглэгчдийн тоог 1140 гэж тодорхойлж болох ба 100 хүнд хогдох хэмжээгээрээ 11.4 байна.

Судалгаанд хамрагдагсдын найз нөхдийн дунд мансууруулах, сэтгэц нөлөөт бодис хэрэглэдэг хүн байсан ба хэрэглэгчдийн 72% нь найз нөхөдтэйгээ хамт хэрэглэдгээс үзэхэд

мансууруулах, сэтгэц нөлөөт бодисын хэрэглээнд бусдын нөлөө их байгааг илтгэнэ. Түүнчлэн 90%-д нь найз нөхөд буюу таньдаг хүнээс нь мансууруулах, сэтгэц нөлөөт бодис хэрэглэх талаар санал болгосон нь хэрэглээг нэмэгдүүлэхэд нөлөөлжээ.

Судалгаанд хамрагдсан хэрэглэгчид мансууруулах, сэтгэц нөлөөт бодисын талаар ойлголттой, мэдээллийг найз нөхдөөсөө авдаг 23,3%, хэвлэл мэдээлэл, TV, интернетээс авдаг 30% нь байгаагаас үзэхэд буруу ташаа мэдээллийг илүү авдах магадлалтай. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис /хар тамхи/-ын хор хөнөөлийг 65% нь сайн мэднэ гэж хариулсан. Иймээс уг бодисын хор хөнөөлийн талаар өсвөр үеийнхний мэдлэгийг дээшлүүлэх шаардлагатай гэж 82% нь хариулжээ.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсний улмаас судалгаанд хамрагдагсад 84% бие махбодын ямар нэг эмгэгт өртсөн ба сэтгэцийн эмгэг болох хий юм харах 33%, мартамхай, юм ойлгохдоо удаан болох 32%, эцэж турах 34% зэрэг шинж тэмдэгүүд зонхилон илэрч байна.

Мансууруулах болон сэтгэц нөлөөт эм, бодисын хууль бус эргэлттэй холбоотой асуудал нь манай улсын хувьд харьцангуй шинэ, хэрэглэгчид нь нийгэмд ил байдаггүй, нуугдмал далд байдаг тул судалгаанд уг бодистой холбоотой гэмт хэрэгт ял шийтгэгдсэн болон шалгагдаж буй 30 хүнийг шууд сонгон авсан нь энэхүү судалгааны хязгаарлагдмал тал байлаа. Нөгөөтэйгүүр 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн эрүүгийн хууль, тогтоомжуудад заасны дагуу хорих ял эдэлж буй ялтнуудын тоо эрс цөөрсөн /15 ялтан буюу хар тамхины хэргээр ял эдлэгсдийн 50 хувь нь хуулийн тэгшгэлээр суллагдсан/, үүнийг дагалдаад энэ төрлийн гэмт хэрэгт ял шийтгэгдэгсдийн тоо ч тэр хэмжээгээр буурсан нь нийт ялтнуудыг ангилах шаардлагыг үгүйсгэж байгаа юм.

Энэхүү социологи судалгааг хийснээр нөхцөл байдлыг илүү бодитой тодорхойлж, цаашид бодлогын түвшинд анхаарах зүйлсийг илүү тод харагдуулахыг зорьсон болно.

#### ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ БОЛОН АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮНД ХИЙСЭН СУДАЛГАА

Энэ параграфийн хүрээнд ОХУ, БНХАУ-ын эрүүгийн эрх зүйн болон ялын бодлогыг судлан, өөрийн орны эрүүгийн хууль, ялын бодлоготой харьцуулан дүгнэлт хийхийг зорьлоо.

##### **2.1 Монгол Улсын эрүүгийн эрх зүйн орчин, ялын бодлого**

Монгол Улс нь Мансууруулах бодисын тухай 1961 оны конвенцид 1990 онд, Сэтгэцэд нөлөөт бодисын тухай 1971 оны конвенцид 1999 онд, Мансууруулах бодис ба сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг 1988 оны конвенцид 2001 онд, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн конвенцид 2008 онд тус тус нэгдэн орсон.

Мөн 2002 онд батлагдсан Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль, хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2003 оны 196 дугаар тогтоол, Улсын Их Хурлын 2008 оны 35 дугаар тогтоолоор баталсан “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4 дүгээр бүлэг, 2010 оны “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.4.3 дахь хэсэг, Засгийн Газрын 2010 оны 277 дугаар тогтоолоор баталсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн эргэлтэд хяналт тавих зорилгоор мэдээлэл солилцон хамтран ажиллах журам”, Төрийн ордны Иргэний танхимд 2012 оны 03 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулагдсан “Хар тамхи, мансууруулах бодисын нөхцөл байдал” сэдэвт хэлэлцүүлгээс гаргасан тогтоол, зөвлөмж, журам, 2017 оны 03 дугаар сарын 07-н өдрийн Засгийн газрын 77 дугаар тогтоолоор батлагдсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх” үндэсний хөтөлбөр зэрэг эрх зүйн актуудаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой харилцаа зохицуулагдаж байна.

ХЗДХЯ-ны ГХУСАЗ Зөвлөл болон Засгийн газрын 2017 оны 27 дугаар тогтоолоор шинээр байгуулагдсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих үндэсний хороо” нь хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж байна.

Манай улсын эрүүгийн эрх зүйн бодлого энэ төрлийн гэмт хэрэгт оногдуулах ял, шийтгэлээр дамжиж хэрхэн хэрэгжиж байсан болон энэ бодлого нь олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн эрх зүйн хэм хэмжээ, үзэл баримтлалд хэрхэн нийцэж байсныг товчхон танилцуулвал:

1986-2002 ондуудад буюу 17 жил хэрэгжсэн эрүүгийн хуулинд энэ төрлийн бодисыг борлуулах зорилгогүйгээр олж авсан, бэлтгэсэн, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, түүнчлэн эдгээр бодисыг үйлдвэрлэх, олж авах, тавьж олгох, хадгалах, бүртгэх, тээвэрлэх, илгээх талаар журам зөрчсөн бол 3 жил хүртэл хугацаагаар хорих эсвэл 1.6 жил хүртэл хугацаагаар засан

хүмүүжүүлэх ажил хийлгэх, харин, борлуулсан борлуулах зорилгоор олж авсан, бэлтгэсэн, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн болон борлуулсан бол 8 хүртэл жил, зохион байгуулалттай бүлэг, онц аюултай гэмт хэрэгтэн, мансууруулахаас бусад хүчтэй үйлчлэх болон хорт бодисыг үйлдвэрлэх, олж авах, хадгалах, тавьж олгох, бүртгэх, тээвэрлэх, илгээх журам зөрчсөн хэрэгт ял шийтгэгдэж байсан хүн үйлдсэн, эсхүл их хэмжээтэй буюу давтан үйлдсэн, хүүхдэд энэ төрлийн бодисыг худалдсан, тэднээр худалдуулсан, энэ үйлдэлдээ бусад хэлбэрээр хүүхдийг оролцуулсан бол хүндрүүлэн үзэж 10-25 жилийн хорих ял шийтгэх зохицуулалттай байсан.

Энэ хуулийн зохицуулалтанд 18 насанд хүрээгүй хүнийг/хүүхдийг энэ гэмт хэрэгт татан оролцуулсан бол хүндрүүлж үзэхээр заасан нь хүүхдийг мансууруулах болон сэтгэцэд нөлөөтэй бодисын тухайд эрүүгийн эрх зүйн хувьд халамжилж байсан бодлого гэж үзэхээр байна.

2002 онд шинэчлэн баталсан эрүүгийн хуулинд мансууруулах болон сэтгэцэд нөлөөтэй бодистой холбоотой гэмт хэргийн тоог нэмэгдүүлж хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах үйлдлийг эрүүжүүлэхээс гадна энэ бодисыг хэрэглэх газрыг зохион байгуулах, уг бодисыг хууль бусаар авах, тарьж ургуулах, хурааж авах, хилээр хууль бусаар нэвтрүүлэх зэрэг үйлдлүүдийг эрүүжүүлж оногдуулах хариуцлагыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100-150 дахин нэмэгдүүлсэн мөнгөн дүнгээр торгох, 3-6 сар хүртэл хугацаагаар баривчлах, 25 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан.

Харин 2017 онд шинэчлэн батлагдсан эрүүгийн хуулиар энэ төрлийн бодис, түүхий эдийг худалдах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн, хадгалсан, бусдад өгсөн, худалдах зорилгоор хууль бусаар олж авсан, бэлтгэсэн, борлуулсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, худалдсан, дээрх үйлдийг байнга тогтвортой хийсэн, зохион байгуулалттай бүлэг үйлдсэн, энэ төрлийн бодис хэрэглэх орон байраар хангасан, уг бодисыг завшсан, хууль бусаар тариалсан, улсын хилээр хууль бусаар оруулж ирсэн үйлдүүдийг эрүүжүүлж оногдуулах хариуцлагыг эрх хасах, 4 670 000-400 000 000 төгрөгөөр торгох, 1-5 жил хүртэл хугацаагаар зорчих эрх хязгаарлах, 1-12 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан.

1986 оноос 2017 оны 7 дугаар сарын 1-нийг хүртэл мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой тэмцэх төрийн бодлогод 18 хүртэлх насны хүмүүсийг хамгаалах эрүүгийн эрх зүйн зохицуулалт байсан бөгөөд энэ төрлийн бодис хэрэглэх нь хувь хүний асуудал тул хүлээлгэх хариуцлага нь харьцангуй хөнгөн, харин бусдыг уруу татах нь хүндрүүлэх үндэслэл болж, хорих ялын хэмжээг 8 жил хүртэл хугацаагаар оногдуулахаар байжээ. Тухайлбал: Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлийг тайлбарласан УДШ-ийн 2008.6.25-ны 29 дүгээр тогтоолд зааснаар мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг бусдад төлбөртэй болон төлбөргүйгээр шилжүүлэхийг борлуулсанд тооцно гэсэн байдаг. Харин шинэчлэн батлагдсан эрүүгийн хуулинд уг бодисыг бусдад өгөх, худалдах гэсэн 2 нэр томъёо оруулсан нь бусдыг мансууралд уруу татаж, уг бодисыг санал болгосон нь хариу төлбөргүй тохиолдолд худалдсан гэж тооцогдохгүй 5 жил хүртэл хорих ял оногдуулж өмнө нь оногдуулж байснаас даруй 3 жилээр бага ялтай болжээ.

Хэдийгээр ял шийтгэлийг бууруулах нь буруу биш боловч үндэслэлтэй, хасагдаж буй ялын орон зайг эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээгээр нөхөх шаардлагатай. Өөрөөр хэлбэл эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авах эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай заалтыг тодорхой зүйл хэсэгт тусгасан байвал зохино.

Монгол Улсын “Өршөөл үзүүлэх тухай” 2015 оны хуулийн дагуу 9.7 сая төгрөгийн торгууль төлөх, 4 сар баривчлагдахаас 18 жил хорих ялтай байсан 13 ялтан, 2017 оны шинэчилсэн Эрүүгийн хуулийн дагуу 1-15 жилийн хорих ялтай 15 ялтан хугацаанаасаа өмнө ялаас чөлөөлөгдөж, сүүлийн 1.9 жилийн хугацаанд энэ төрлийн бодистой холбоотой 28 хүн хорих ангиас суллагдаснаас гадна 27 ялтнуудын шүүхийн шийдвэрээр оногдуулсан ялаас 2-5 жилийг хассан байна.

Хорьж шийтгэх байдлаар тэмцэх нь зөв биш гэж үзэж хугацааны хувьд хассан нь хүний эрх зүйн байдлыг дээрдүүлсэн, нөгөө талаасаа уг бодисыг ашгийн төлөө худалдан борлуулж буй үйлдлийг хүмүүсийн сонирхлыг нь дагуулж ашгийн бус хэлбэрээр бусдад санал болгож байгаа үйлдлээс ялгамжтай үзэж ял шийтгэх талаасаа энэ нь дэвшил боловч хассан 3 жилийн хорих ялын орон зайг хариуцлагын бусад төрлөөр, тухайлбал албадан эмчлэх эрүүгийн хариуцлагын арга хэмжээгээр нөхөх ёстой байсан.

## **2.2 Бүгд Найрамдах Хятад Ард Улсын эрүүгийн эрх зүйн бодлого**

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын эрүүгийн бодлого нь героин, амфетамин, морфин, олсны ургамал /каннабис/, кокаин болон улсын хяналтанд байвал зохих, хүнд донтох зуршил бий

болгох магадлалтай мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг ойлгох ба тэдгээрийг хилээр нэвтрүүлсэн, худалдсан, тээвэрлэсэн, үйлдвэрлэсэн бол хэмжээнээс үл хамааран эрүүгийн хариуцлага тооцно.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой дараах тохиолдлуудыг гэмт хэрэгт тооцож ял оногдуулдаг байна. Үүнд:

- Хууль бусаар олж авсан /зорилгоо заагаагүй/, хилээр нэвтрүүлсэн, худалдсан, тээвэрлэсэн, үйлдвэрлэсэн, тариалсан, устгахыг эсэргүүцсэн,
- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт бүлэг, зохион байгуулалттай гэмт бүлгийн үйл ажиллагаанд оролцсон, гэмт үйлдэлдээ галт зэвсэг, хэрэгсэл хэрэглэх, хууль сахиулах ажиллагааг эсэргүүцэн тэмцэлдэх зэрэг хууль бус үйлдэл гаргасан,
- Гэмт үйлдэлдээ насанд хүрээгүй хүнийг ашиглах, турхирах, гэмт этгээдийг хаацайлж, гэмт этгээдэд мансууруулах бодис эсхүл гэмт хэргээс олж авсан эд зүйлсийг нуун далдалж, шилжүүлэн зөөсөн, нуун дарагдуулсан,
- Цууны исэл, эфир, хлороформ болон бусад мансууруулах бодис үйлдвэрлэхэд ашиглагдах түүхий эд, дагалдах бодисыг хилээр нэвтрүүлсэн, эсхүл хууль, тогтоомж зөрчиж улсын нутаг дэвсгэрт дээрх зүйлсийг хууль бусаар наймаалах, мансууруулах бодис үйлдвэрлэж буйг мэдсээр байж дээрх зүйлсээр хангасан,
- Мансууруулах бодисын эх ургамлууд эсхүл үрслүүр, бодис татах, тарих газар, оройн байраар хангах,
- Хяналтад байвал зохих мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг албан тушаалаа урвуулан ашиглах замаар завшсан зэрэг болно.
- Бусдыг уруу татах, турхирах, хууран мэхлэх замаар мансууруулах бодис татуулсан, тариулсан, насанд хүрээгүй хүнийг уруу татах, турхирах, хууран мэхлэх замаар мансууруулах бодис татах, тарихад хүргэх нь хүндрүүлэх үндэслэл болох ба Амфетамин, Метамфетамин, Геройн зэрэг хүчтэй үйлчилгээтэй байж болох нэр төрөл, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хэмжээ, чанарын үзүүлэлтийг ял оногдуулахдаа харгалзан үзэж торгох, 3 жилээс хугацаагүй хорих, цаашлаад цаазаар авах хүртэл ялтай. Эрүүгийн хариуцлага хүлээх субъект нь хувь хүнээс гадна, хуулийн этгээд байх зохицуулалттай.

Тус улсад мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хэмжээнээс нь хамаарч хүндрүүлэх нөхцөл байдал мөн эсэхийг тогтоохоос гадна хүүхэд, өсвөр насныхныг энэ хэрэгт уруу татсан, ашигласан тохиолдлыг мөн хүндрүүлж үзэж цаазаар авах хүртэл ял оногдуулах эрх зүйн зохицуулалттай байна. Энэ нь хүүхэд, өсвөр үеийнхнийг хамгаалсан, урьдчилан сэргийлэх агуулгатай эрүүгийн эрх зүйн бодлогын давуу тал юм.

БНХАУ-ын улсын хэмжээнд 2016 оны байдлаар 2 сая 345 мянган мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэгч байна гэж үзсэн байна. Мөн уг бодистой холбоотой 165 мянган гэмт хэрэг бүртгэгдсэнээс, хэрэгт холбогдуулан 194 мянган хүнийг сэжигтнээр татсан бол 102.5 тонн бодис хураан авсан байна. Тус улсын мансууруулах бодист хяналт тавих хороо<sup>1</sup> Тус хороо нь 1990 онд “БНХАУ-ын мансууруулах бодист хяналт тавих хороо” нэртэйгээр Гадаад харилцааны яам, НАХЯ, Ардын дээд шүүх, Ардын дээд прокурор, Хууль зүйн яам, Ардын засгийн газар, Боловсролын яам зэрэг 23 удирдах байгууллагын 25 гишүүнээс бүрдсэн байгууллага юм. Тус хороог НАХЯ-ны Сайд давхар удирддаг байна. Үүний зэрэгцээ НАХЯ-ны харьяанд “Мансууруулах бодисын хяналтын товчоо” бие даасан газрын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг.

### **2.3 Оросын Холбооны Улсын эрүүгийн эрх зүйн бодлого**

Тус улсад мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын гэмт хэрэг хүүхэд, өсвөр насныханы хувьд гэмт хэрэгт ашиглагдах, эсвэл өөрсдөө гардан гүйцэтгэх, зохион байгуулах аль ч хэлбэрээр холбогдож байна. Ихэнх тохиолдолд насан хүрэгчид тэднийг ашиглан гэмт хэрэг үйлдэх нь хариуцлагаас зайлсхийх гэсэн оролдлоготой нь холбоотой байна. Тус улсад нөхцөл байдалтай уялдуулан 2003 оны 11 сард Холбооны хар тамхитай тэмцэх хороог байгуулсан бөгөөд энэ байгууллага нь 40 000 хүний орон тоотой, жилийн 810,794 ам долларын төсөвтэй, засгийн газрын бие даасан агентлаг байгуулж ажиллаж байсан. Хэдийгээр 2016 онд дээрх байгууллага татан буугдаж, эрх, үүрэг нь Дотоод хэргийн яамандаа шилжсэн ч энэ нь тухайн асуудал нь шийдвэрлэхэд ямархуу бэрхшээлтэй болсныг харж болон байна.

Тус улсын судлаачдын<sup>1</sup> үзэж байгаагаар:

<sup>1</sup> Т.Г.Газизовагийн 2016 онд хийсэн судалгаа.

- Өсвөр насныхан нь бусдын, ялангуяа насанд хүрэгчдийн үгэнд амархан ордог, тэдний дарамт шахалт, албадлага зэргийг хүлцэнгүй дагаж биелүүлдэг.

- Өсвөр насны хүүхдүүдээр хар тамхины төрлийн зүйлс заруулах нь хууль сахиулах байгууллагын хараа, анхааралд өртөхгүй байх боломжтой байдаг.

- Үе тэнгийн хүүхдүүтэйгээ нийтэч зан, байдлыг ашиглан амархан харилцаа холбоо тогтооход хялбар. Түүнчлэн өсвөр насны хүүхдүүд нь насанд хүрсэн хүмүүсийн хүрч чадахгүй, хүндрэлтэй тэр орчин, газруудад хар тамхины төрлийн зүйлсээ зарж борлуулах боломж нь илүү байдагтай холбоотой. Тухайлбал: ЕБС, тусгай дунд болон их дээд сургуулиуд, мөн оюутны дотуур байр гэх мэт шалтгаанаар энэ төрлийн бодистой холбоотой гэмт хэрэгт холбогддог, улмаар хэрэглэх сэдэл, нөхцөл байдал бүрддэг гэжээ.

Тус улсад мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой дараах тохиолдлуудыг гэмт хэрэгт тооцож ял оногдуулдаг байна. Үүнд:

- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис буюу тэдгээртэй адилтгах зүйлийг хууль бусаар үйлдвэрлэх, борлуулах буюу илгээх, ашиглан шамшигдуулах, эсхүл авахаар далайлган сүрдүүлэх, хэрэглэхэд бусдыг хатгах,

- Тариалахыг хориглосон ургамлыг тарих буюу ургуулах, түүнчлэн олс, намуу цэцэг буюу мансууруулах бодис агуулсан бусад ургамлыг тариалах,

- Мансууруулах хэрэгсэл буюу сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэх байр байгуулсан, тэтгэх,

- Уг бодисыг хууль бусаар олгох, жор буюу олж авах эрх олгосон бусад баримт бичгийг хуурамчаар үйлдэх,

- Тусгай хяналтад байвал зохих бусад бодис үйлдвэрлэх ба бэлтгэхэд ашиглах адитгал, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг гаалийн хилээс гадуур буюу гаалийн хяналт шалгалтаас нуун дарагдуулж, эсхүл баримт бичиг буюу гаалийн адитгалын хэрэгсэл ашиглан хууран мэхэлж, эсхүл мэдүүлээгүйгээр буюу зохиомлоор мэдүүлж, улсын хилээр нэвтрүүлэх, түүнд албан тушаалынхаа байдлыг ашиглах,

- Уг бодистой адилтгах зүйлийг борлуулах зорилгогүйгээр хууль бусаар үлэмж хэмжээгээр олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн, бэлтгэсэн, дахин боловсруулах,

- Уг бодисыг бэлтгэхэд ашиглагдах багаж хэрэгсэл ба тоног төхөөрөмжийг үйлдвэрлэх, бэлтгэх, дахин боловсруулах, хадгалах, бүртгэх, борлуулах, худалдах, хуваарилах, тээвэрлэх, илгээх, олж авах, ашиглах, гаргах, оруулах, эсхүл устгах журам зөрчсөн, түүнчлэн тэдгээрийг үйлдвэрлэхэд ашиглагдах ургамлыг тариалах журмыг түүнийг мөрдөх, мөрдүүлэх үүрэг бүхий этгээд зөрчсөнөөс тэдгээр нь алдагдсан, эсвэл шунахай сэдэлтээр үйлдсэн, хүний эрүүл мэндэд гэм хор буюу өөр хүнд хор уршиг болгоомжгүй учруулах зэргийг гэмт хэрэгт тооцож, ял оногдуулахаар заасан.

Гэмт хэрэг үйлдэж, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис буюу эдгээртэй адилтгах зүйлийг сайн дураараа шилжүүлэн өгсөн ба мансууруулах хэрэгсэл, сэтгэцэд нөлөөт бодис буюу эдгээртэй адилтгах зүйлийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг илрүүлэх буюу таслан зогсоход идэвхтэй тус дөхөм үзүүлсэн, түүнийг үйлдсэн этгээдийг илчилсэн, гэмт замаар олсон эд хөрөнгийг илрүүлсэн этгээдийг энэ гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө. Харин албадан саатуулах болон хууль сахиулах үйл ажиллагааны үеэр илрүүлсэн ба гаргуулан авсаныг сайн дураараа өгсөн гэж үзэхгүй.

Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй этгээдэд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх, эсхүл түүнд ял ногдуулах ба ялаас чөлөөлж, боловсролын сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад байлгаж болно.

Гэмт хэрэг үйлдсэн, 16 насанд хүрээгүй хүүхдэд 6, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, түүнчлэн 18 насанд хүрээгүй хүүхдэд 10 жил хүртэл хугацаатай хорих ял ногдуулж, хүмүүжүүлэх ангид ялыг нь эдлүүлнэ.

Энэ үедээ хөнгөн буюу хүндэвтэр гэмт хэрэг анх удаа үйлдсэн бол ял ногдуулахгүй. Хүнд эсхүл онц хүнд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрэгсдэд оногдуулахаар заасан ялын доод хязгаарыг тал хувиар багасгах ба ял хөнгөрүүлэх нөхцөл байдал болсон насанд хүрээгүй байдлыг ял хөнгөрүүлэх ба хүндрүүлэх бусад нөхцөл байдалтай нийлбэр цогцоор нь харгалзан үзнэ.

Оросын холбооны улсад 2010-2015 онд энэ төрлийн гэмт хэргийн статистик тоон үзүүлэлт нь тогтворгүй байсан. 2010-2014 онд өссөн үзүүлэлттэй байсан бол 2015 оноос тодорхой хэмжээнд буурсан. Буурсан шалтгаан нь хууль сахиулах үйл ажиллагааны үр дүнтэй холбон дүгнэж болно.

Сүүлийн 5 жилд өсвөр насны хүүхэд оролцсон мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүүхдийн тоон үзүүлэлт.




График 59

Өсвөр насны хүүхдүүдийн холбогдсон хар тамхины гэмт хэрэг, зүйл ангиар.

Эрүүгийн хуулийн зүйл ангиуд	228-р зүйл	228.1-р зүйл	229-р зүйл	229.1-р зүйл	230-р зүйл	231-р зүйл	232-р зүйл	234-р зүйл
Мансууруулах бодисын хууль бус худалдаатай холбоотой гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүүхдийн тоо	12253	3143	11	3	13	16	12	37

#### 2.4 Авч, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны үр дүнд хийсэн дүн шинжилгээ

Энэ хэсэгт цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны сүүлийн 5 жилд хийсэн ажилд дүн шинжилгээ хийсэн.

##### 2.4.1 Урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажил.

Сүүлийн 5 жилийн хугацаанд Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаагийн байгууллага дараах ажлыг зохион байгуулсан байна. Үүнд:

- 2013-2017 онуудад /2016 онд хөрөнгийн асуудал шийдвэрлэгдээгүй тул устгал хийгдээгүй/ манай улсын Төв, Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Булган, Хэнтий, Дорнод, Хөвсгөл аймгуудад ургаж буй Зэрлэг олсны ургамал /каннабис/-ын тархац тогтоогдсон 1497.8 га талбай /дахардсан тоо/-д устгал хийхэд 360.2 сая төгрөгийг зарцуулсан.

- “Мансуурал бодис” арга хэмжээг 2012 онд зохион байгуулж энэ төрлийн эм бэлдмэл үйлдвэрлэдэг, борлуулж түгээдэг үйлдвэр 12, хүн эмнэлэг 356, мал эмнэлэг 14, эм ханган нийлүүлэх байгууллага 66, эмийн сан 592-д хамтарсан шалгалт зохион байгуулжээ. Арга хэмжээний хүрээнд зарим эмийн сангийн үйл ажиллагааг зогсоож, хууль тогтоомжоор бүртгэлд ороогүй эм бэлдмэлийг хураасан.

- “Хяналт” нэгдсэн арга хэмжээг 2016 онд зохион байгуулж, ахуйн хэрэглээний шингэрүүлсэн хий худалдаалж буй 892 аж ахуй нэгж байгууллагад албан мэдэгдэл өгчээ. Ингэснээр насанд хүрээгүй хүнд ахуйн шингэрүүлсэн хийг худалддаг байдал эрс буурсан.

- Нийслэлийн боловсролын газар, Монголын оюутны холбоо, Их дээд сургууль, мэргэжлийн коллежийн оюутнуудын дунд “Мансууралгүй ирээдүй” аяныг зохион байгуулснаар 20 их, дээд сургууль, 5 мэргэжлийн коллеж, 102 ерөнхий боловсролын сургуулийн 900 оюутан, 1200 сурагчид эрсдлээс сэргийлэх мэдээллийг авсан байна. Түүнчлэн фэйсбүүк, бусад цахим мэдээллийн хэрэгсэл ашиглан 150 удаагийн ухуулга, сурталчилгаа, сэрэмжлүүлэг явуулсан нь нийслэлийн 56 дунд сургуулийн 9400 орчим сурагчид тухайн цахим хуудсанд хандсан байна.

- Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүл мэнд, спортын яам, Гааль, Татварын ерөнхий газар, Гадаадын иргэн, харъяатын газар, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв болон энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай хамтран 2015 онд “Хар тамхины эсрэг хамтдаа” сэдэвт өдөрлөгийн арга хэмжээг Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал дахь хилийн боомт, Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь хилийн боомтод 2016 онд “Мансууралгүй ирээдүй” арга хэмжээг зохион байгуулсан.

*2.4.2 Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, гэмт хэргийг илрүүлэх чиглэлээр.*

- Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор ЦЕГ-ын даргын 2017 оны А/23, А/133 дугаар тушаалаар Эрүүгийн цагдаагийн албаны Хар тамхитай тэмцэх хэлтсийг Хар тамхитай тэмцэх газар 33 алба хаагчийн орон тоотой байгуулсан.

- Цагдаагийн байгууллагаас 2006-2016 онд үйлдэгдсэн энэ төрлийн гэмт хэрэгт дүн шинжилгээ хийхэд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг нийт гэмт хэргийн 0,2 хувийг, үүнээс 82,1 хувь нь Улаанбаатар хотод, 17,9 хувь нь хөдөө орон нутагт бүртгэгдсэн байна. Жилд дунджаар 32, сард 3 гэмт хэрэг үйлдэгдэж буй судалгааг гаргасан байна. Мөн дээрх төрлийн гэмт хэрэгт холбогдож буй хүмүүсийг нас, хүйсээр нь авч үзвэл 81.9 хувь нь эрэгтэй, үүнээс 18-24 насны залуучууд 65 хувийг эзэлж байгаа нь уг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, хууль бус эргэлтэд хяналт тавих ажлыг чангатгах, байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, алба хаагчдыг сургаж, мэргэшүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлага гарсан. Учир нь гэмт хэрэгт холбогдон шалгагдсан хүмүүсийн тоо жил ирэх тутам нэмэгдэж байна. 2017 оны 10 дугаар сарын 30-ны байдлаар цагдаагийн байгууллага 202 хүнд холбогдох энэ төрлийн 66 гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан байна.

- 2010-2012 Малайз-УБ-Бээжин, Бангладеш-УБ-Бээжин, Лаос-Малайз-УБ-Бээжин гэсэн чиглэлд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг тээвэрлэх, дамжин өнгөрүүлдэг бүлэг этгээдүүдийг илрүүлж, урсгалыг таслан зогсоосон<sup>2</sup>.

- 2017 оны 05 дугаар сараас 11 дүгээр сарын 26-ны хооронд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх хамтарсан төслийг Бүгд Найрамдах Солонгос Улсын Ерөнхий прокурорын газартай амжилттай хэрэгжүүлж, Солонгосын тал Эрүүгийн цагдаагийн албаны Хар тамхитай тэмцэх газарт дараах техник хэрэгслийг хүлээлгэж өгсөн. Үүнд:

<b>Эд зүйлийн нэр</b>	<b>Тоо хэмжээ /ширхэгээр/</b>
Мансууруулах бодис шинжлэх тест	3 345
Хьюндай Старекс Н-1	1
Ионскан төхөөрөмж IONSCAN 600	2
Тактикийн цамц, өмд, тэлээ	17
Гуяанд бэхэлдэг агсамж	5
Хийн буу “Fort” 17P	5
Хийн буу “Fort” 500AC	2
9 мм-ийн хийн бууны сум	250
12 мм-ийн хийн бууны сум	100
Камертай гар чийдэн	1
Дуулга	12
Гар бууны гэр	10
Гар бууны оосор	10
Тактикийн маск	12
Шөнийн дуран	1
Цонх хагалагчтай гар чийдэн	9
Мансууруулах болон тэсэрч дэлбэрэх бодис илрүүлэх “IonScan” төхөөрөмж	2

<sup>2</sup> ЭЦА-ны Хар тамхитай тэмцэх газраас ирүүлсэн тайлан




## ГУРАВ: ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улсад 2010 оныг хүртэлх хугацаанд байгалийн гаралтай хогийн олсны ургамал /каннабис/-ын төрлийн мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг ихэнх хувийг эзэлж байсан бол 2011 оноос химийн аргаар боловсруулсан сэтгэцэд нөлөөт бодис болох амфетамин, метамфетамин агуулсан мөс /ICE/ гэх нэршилтэй бодисын хэрэглээ ихсэж нийгмийн бүхий л давхаргын хүмүүсийг хамарч, хэргийн гаралт, холбогдогчдын тоо тогтмол өсч, нас залуужиж байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Цагдаа, хил, гаалийн байгууллагаас ирүүлсэн мэдээллээс үзвэл Монгол Улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус нийлүүлэлт БНХАУ, ОХУ болон зүүн өмнөд азийн орнуудаас гэсэн 3 урсгалаар амфетамин, метамфетамин төрлийн болон мансууруулах ургамлын гаралтай бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн, нэвтрүүлэхийг завдсан, зарж борлуулсан гэмт хэрэг, зөрчил ихсэж байна.<sup>3</sup> Мөн Монгол Улсын эмийн бүртгэлээс хасагдсан “Анданте” нэртэй эмийг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэх, зарж борлуулах, мансуурах зорилгоор хэрэглэх үйлдэл эрс нэмэгдсэн. Иргэд богино хугацаанд их хэмжээний ашиг олох, орлогын эх үүсвэр болгох, улсын хилээр нэвтрүүлэх арга, хэлбэр нарийсч олон улсын шуудан илгээмж, карго ашиглах болсон, 2012 оноос 2017 оны эхний хагас жилийн хооронд сүүлийн 5 жилийн хугацаанд энэ төрлийн бодистой холбоотой гэмт хэргийн гаралт 3,6 дахин өссөн.

Цагдаагийн байгууллагын хийсэн дүн шинжилгээгээр мансууруулах, сэтгэц нөлөөт бодис тогтмол хэрэглэдэг 5000-7000 хэрэглэгч байгаа ба тэдний сарын хэрэглээг 1 хэрэглэгчийг 1 гр гэж тооцвол 5-7 кг мансууруулах бодис байна. БНХАУ-ын Эрээн хотын Гаалийн цагдаагийн газрын тооцоолсноор сард 10 кг мөс буюу ice гэх мансууруулах бодис тус улсын хилээр нэвтэрч Монгол Улсад орж байгаа гэсэн тооцоолол гаргасан байна. 1 грамм мөсийг 400,000 төгрөг гэж үзвэл сард 4 тэрбум, жилд 48 тэрбум төгрөг мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэнд эргэлдэж байна.

2013 оноос 2017 оны 06 дугаар сар хүртэл хугацаанд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн энэ төрлийн гэмт хэрэг, тэдгээрт холбогдсон хүмүүс: Хүснэгт 60<sup>4</sup>



Энэ оны 12 сарын 10-ны байдлаар манай улсын 42 иргэн ОХУ, БНХАУ, Сигапур зэрэг улсуудад энэ төрлийн гэмт хэрэгт холбогдон шалгагдаж<sup>5</sup> байна.

Үүнээс гадна газар зүйн нөхцөл байдлын онцлогоос шалтгаалж манай орны зарим нутаг дэвсгэрт мансууруулах төрлийн ургамал ургадаг, түүнийг устгах ажил хангалттай зохион байгуулагддаггүй. Хүүхэд, залуучууд бие биеэсээ сонсох, даган дуурайх, олон нийтийн хэрэгсэл, интернет цахим хуудсаар хар тамхи, мансууруулах бодисын ойлголт, хэрэглэх аргыг сурч байгаа нь энэ төрлийн гэмт хэргийг үйлдэх сэдэл, шалтгаан нөхцөл нь болж байна.

Хяналт, шинжилгээ хийх зориулалт бүхий техник, технологи шаардлагын хэмжээнд хүрдэггүй, хэрэглэгч, донтогч болсон тохиолдолд үзүүлэх эмнэлгийн болон сэтгэл зүйн, нийгмийн тусламж үйлчилгээний стандарт байхгүй зэргээс шалтгаалж нөхцөл байдал хүндрэх эрсдэлтэй байна. Хүүхэд, залуучууд бие биеэсээ сонсох, даган дуурайх, мөн телевиз,

<sup>3</sup> Хар тамхитай тэмцэх газрын Мөрдөх хэлтсийн танилцуулга/2017 он/

<sup>4</sup> ЦЕГ-ын гэмт хэргийн статистик мэдээ

<sup>5</sup> ГХЯ-ны Консулын газраас авсан мэдээлэл

интернетээс ямар ч шалгуур, цензургүй мэдээлэл авах боломж нээлттэй байна. Иргэд богино хугацаанд их хэмжээний ашиг олох, орлогын эх үүсвэр болгох зорилгоор энэ төрлийн гэмт хэргийг үйлдэх, тээвэрлэх явдал ихэссэн, хяналт, шинжилгээ хийх зориулалт бүхий техник, технологи шаардлагын хэмжээнд хүрдэггүй. Хэрэглэгч, донтогч болсон тохиолдолд үзүүлэх эмнэлгийн болон сэтгэл зүйн, нийгмийн тусламж үйлчилгээний стандарт байхгүй зэрэг нөхцөл байдал нь энэ төрлийн гэмт хэрэг өсөн нэмэгдэх шалтгаан болж байна.

Шинжилгээний байгууллагын энэ төрлийн бодист шинжилгээ хийх чадамж хангалттай төвшинд хүрээгүй, тухайлбал LSD, Экстази, Эфедриний агууламжтай байдаг Нангиад Зээргэнэ/*Ephedra Sinica*, бусад төрлийн ургамал, бодис, эмүүдэд шинжилгээ хийх тоног төхөөрөмж, стандарт, дээж, урвалж бодис байхгүй, үйлчлэгч бодисыг илрүүлэх боломжгүй байна. Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд 26 хилийн боомтод мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис илрүүлэх техник тоног төхөөрөмжийг суурилуулах, хэрэглэгч, донтогчдыг эмчлэх, тэдэнд туслалцаа үзүүлэх, эмчилгээний байгууллага, мэргэшсэн эмч ажилтан, наркологийн кабинет, төвтэй болох асуудал шийдвэрлэгдээгүй. Зэрлэг олс/каннабисыг устгах хөрөнгө санхүүг улсын төсөвт тусгайлан суулгах зайлшгүй шаардлага байна.

#### ДӨРӨВ: УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Нэгдсэн үндэстний байгууллагаас 2013 онд “Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээнээс урьдчилан сэргийлэх стандарт”<sup>6</sup>-ыг батлагдан гарснаас нь хойш зарчмын шинжгүй өөрчлөлтүүдийг оруулж 2015 онд шинэчилсэн байна.

Энэхүү стандартын гол үзэл баримтлал нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисоос урьдчилан сэргийлэх нь хүмүүст туслах, уг бодисыг хэрэглээд эхэлсэн тохиолдолд түүнээс хараат болох, сэтгэцийн хувьд донтох байдлаас урьдчилан сэргийлэхэд гол зорилго нь оршино. Уг бодисын хууль бус хэрэглээнээс урьдчилан сэргийлэх ерөнхий үзэл баримтлал нь хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл, аюулгүй орчинд амьдрах боломжыг бүрдүүлэх, тэдэнд өөрсдийн авьяас, чадвар, нөөц боломжоо нээх, түүнийгээ нийгмийн сайн сайхныг төлөө хөгжүүлэх явдлыг ухааруулахад оршино. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээнээс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй арга хэмжээ нь хүүхэд, өсвөр үеийнхэн, тэдний гэр бүл, сургууль, ажлын байр болон олон нийтээр дамжуулан нөлөөлөх явдал юм.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис болон тэдгээрийн хор хөнөөлийн талаарх мэдлэг муу байдлаас илүүтэй дараах эрсдлийн хүчин зүйлүүд байгааг нотлох баримтанд үндэслэн дурьдвал: Биологийн процесс, хувь хүний зан чанарын онцлог байдал, сэтгэцийн эрүүл мэндийн асуудал, гэр бүлийн тогтворгүй байдал түүнээс үүдэлтэй сөрөг уур амьсгал, сургууль завсардалт, зожигрол, нийгэмд биеэ авч явах байдал, орчны нөлөө, шоовдорлогдсон нөхцөлд өсөж, хүмүүжих болон олон нийтээс хэт тусгаарлагдмал байдал зэрэг хүчин зүйлсийг дурьдаж болно.

Нөгөө талаас сэтгэл ханамжтай, хувь хүний хувьд нийгмийн идэвхитэй, эцэг эхийн хайр халамжийг мэдэрч өссөн, дотно харилцаатай халуун дулаан гэр бүлийн уур амьсгалтай, сургууль, багш нарын анхаарал халамж дунд сурч буй хүүхдүүдийн хувьд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх зэрэг муу зуршилд автах эрсдэл бага байдаг. Өөрөөр хэлбэл энэ тохиолдолд хүмүүст муу зуршлын эсрэг дархлаа суусан байх нь нийтлэг. Тиймээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь хүүхдийн гэр бүл, сургууль, ажлын байранд нь боловсорлоор дамжуулан уг бодисын хор хөнөөл, үүсэн гарах нийгэм, эдийн засаг, эрх зүйн үр дагаваруудыг таниулахад тусгайлан бэлтгэсэн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж, сургалтын хөтөлбөрт тусгах шаардлагатайг илэрхийлж байна.

Энэхүү стандартыг боловсруулахдаа судалгаанд үндэслэсэн бөгөөд хөгжингүй болон хөгжиж буй орнууд, түүнчлэн цөөн ч гэсэн буурай хөгжилтэй орнуудад хийгдсэн судалгааны тайлангуудад үндэслэн Канадын загварыг барьж боловсруулжээ. Ихэнх судалгаа нь харьцангуй хэмжээнд, онолын түвшинд нөлөөллийн арга хэмжээний үр дүнг судалсан байдаг бол цөөн тооны судалгаанд бодит байдалд нөлөөллийн арга хэмжээний үр дүнг судлан тогтоосон байгаагаас гадна мөн тооны судалгаанд нөлөөллийн бодлого, үйл ажиллагааны (зөвхөн үр дүн, үр нөлөөнөөс гадна) зардлын ашигт үйлийн коэффициентийг тооцсон байдаг.

Олон улсын түвшинд хүмүүст, ялангуяа хүүхдэд эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлж өгөх явдлыг зорилгоо болгодог бөгөөд хүүхэд бүр харилцан адилгүй ба тэдний өсөлт, хөгжилд нийгэм эдийн засаг, соёлын орчин, нөхцөл гол нөлөөтэй.

<sup>6</sup>[https://www.unodc.org/documents/prevention/UNODC\\_2013\\_2015\\_international\\_standards\\_on\\_drug\\_use\\_prevention\\_E.pdf](https://www.unodc.org/documents/prevention/UNODC_2013_2015_international_standards_on_drug_use_prevention_E.pdf)

Тийм ч учраас насны ангиллыг тоогоор бус өсөлтийн хэмжүүрээр тодорхойлж, урьдчилан сэргийлэх ажлыг тус бүрт нь тохирсон арга бхрил, хэлбэрээр явуулах ёстой.

Ерөнхийдөө, нярай болон бага нас гэдэгт сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг ойлгох ба 0-5 насыг хамаарна, өсвөр насны өмнөх гэдэгт бага сургуулийн сурагч буюу ойролцоогоор 6-10 нас, өсвөр насны гэдэгт дунд сургуулиас ахлах сургуулийн эхэн буюу 11-14 нас, идэр нас гэдэгт ахлах ангийн сурагч буюу 15-18 зарим тохиолдолд 19 насыг, түүнээс дээш насныхныг насанд хүрэгчид гэж ангилна.

Хүний амьдарлын тодорхой үе шат бүрт тохирсон сэтгэл зүй, хүмүүжил, боловсролор нь дамжуулж мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисоос ангид байх зуршил, чадвар олгох явдлыг чухал гэж үзэж түүнд чиглэсэн бодлого, нөлөөллийн арга хэмжээг тогтоохдоо,

1. Эцэг эх, гэр бүлийн гишүүдийг сурган боловсруулах,
2. Сургууль, багш, сурган хүмүүжүүлэгч нарыг бэлгэх, сургаж багшаар бэлтгэх,
3. Ажлын байр, хүрээлэн буй орчинд тодорхой этгээдүүдэд үүрэг хүлээлгэх,
4. Зөвлөгөө, эмчилгээнд тулгуурлан урьдчилан сэргийлэх боломжтой гэж үзэж байна.

Хүүхэд, өсвөр насныхныг мэнсууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээнээс урьдчилан сэргийлэхийн тулд сэтгэл зүй, зан байдал төлөвших явцад нөлөөлж, өөрсдөөр нь уг бодисын хууль бус хэрэглээнээс татгалзуулах нь хамгийн үр дүнтэй.

#### **4.1 Сургуулийн өмнөх насанд хүүхдийг мансуурлаас урьдчилан сэргийлэх**

Сургуулиас өмнөх хүүхдийн харилцааны анхдагч орчин бол гэр бүл. Хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарын зүй бус харилцаа, гэр бүлийн сөрөг уур амьсгалд өсөж бойжих нь тэдний ирээдүйд тэр хэмжээгээр сөргөөр нөлөөлж, мансууруулах, сэтгэцэд нөлөөлт бодис, бусдын уруу татсан аливаа муу зуршилд автах эрсдэл нэмэгдэж, сэтгэл зүйд нь стресс, бухимдлаас үүдэлтэй тогтворгүй байдал үүсэх магадлал нэмэгдэнэ. Шинжлэх ухааны баталж байгаагаар жирэмсэн эмэгтэйчүүдийн сэтгэл зүй, архи, тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис, эмийн зүй бус хэрэглээ нь урагт нөлөөлдөг. Энэ нь төрсний дараа, хүүхдийн зан суртахууны төлөвшилд сөргөөр нөлөөлж мансууралд өртөх болон аливааг бодитоор үнэлж, дүгнэх чадварт нь хор уршигтай. Хүүхдийг төрөхийн өмнө, жирэмсэн эмэгтэйчүүдэд чиглэсэн, төрсний дараа эх хүүхдийн эрүүл мэндэд чиглэсэн зөвлөгөө, зааварчилгаа өгөх замаар нэг талаасаа хүүхдийн өсөлт бойжилт, эрүүл мэндийг хамгаалж нөгөө талаасаа өсөж, хүмүүжих орчин нөхцлийг хэвийн байлгах үүднээс нийгэм, эрх зүйн шинжтэй зөвлөгөөг мэргэшсэн сэтгэл зүйч, эмч, нийгмийн ажилтнууд тогтмол өгөх замаар урьдчилан сэргийлнэ. Энэ туршлагыг хойд америкт илүү хэрэгжүүлж байгаа үр дүнг судласан тайлан илтгэлүүд<sup>7</sup> байдаг.

Хүүхдийг бага насанд нь хүмүүжүүлэх гол арга нь халамжлан хүмүүжүүлэгчийг сурган боловсруулах, насанд нь тохирсон хэл зүйн боловсрол, хувийн зохион байгуулалт, бусдад туслах, хуваалцах, хамтрах, сайн дураараа хандивлах зэрэг сэтгэлгээ, ур чадваруудыг эзэмшүүлэх явдал болно. Үүнийг гэр бүлийн орчинд эзэмшүүлэх явдал бол хамгийн боломжит хувилбар төдийгүй, үр дүнтэй байх болно.

#### **4.2 Сургуулийн насны хүүхдүүдийг мансуурлаас урьдчилан сэргийлэх**

Энэ насандаа хүүхдүүд ихэнх цагийг гэр бүлээсээ хол, сургууль болон түүний орчинд үе тэнгийнхэнтэйгээ өнгөрөөдөг ч гэсэн гэр бүл нь тэдний хувьд нийгмийн амьдралд хэвших нэг чухал хэсэг нь байсаар байх болно. Гэсэн хэдий ч нэгэнт амьдралын идэвхитэй цаг мөчүүдийг сургууль түүний орчинд өнгөрүүлж байгаа учраас нэг ангийнхан, үе тэнгийн хүүхдүүдийн дунд тэдэнтэй цуг өсөж, хүмүүжнэ гэсэн үг. Тэд л хүүхдийн эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлэх, нийгмийн харилцаанд оролцох, танин мэдэх, хөгжин дээшлэхийн суурь болдог. Тиймээс нийгмийн харилцаанд оролцох хүүхдийн үүрэг, оролцоо, нийгэмших үйл явц энэ үед өрнөж, үе тэнгийнхнийхээ хамт тулгарсан саад бэрхшээлийг шийдвэрлэх, даван туулж, туршлагажиж, тодорхой хэмжээгээр хат суух үйл явц энэ үед л болно. Энэхүү туршлага нь Африк, Ази, Дундад Ази болон Лати Америкийн орнуудад хэрэгжүүлж байгаа туршлага юм<sup>8</sup>.

<sup>7</sup> Niccols, 2012a and Niccols 2012b, Turnbull, 2012

<sup>8</sup> Barlow, 2005; Bühler, 2008; Foxcroft, 2011; Furlong, 2012; Gates, 2006; Jones, 2006; Knerr, 2013; McGrath, 2006; Mejia, 2012; Miller, 2012; Petrie, 2007; Spoth, 2008; Thomas, 2007.

Хүүхдийн энэ насанд хөгжлийнх нь гол хүчин зүйлс нь нас, сэтэгхүйд нь тохирсон хэл ярианы хөгжил, тооцоолон бодох чадвар, хүч чадал, өөрийгөө хянах чадварууд байдгаас гадна зорилго тавьж, түүндээ хүрэх зан үйл, шийдвэр гаргах болон асуудлыг шийдвэрлэх ур чадварууд сууж эхэлнэ. Мөн энэ үед сөрөг үр дагавартай сэтгэл зүйн тогтворгүй байдал /ямар нэг зүйлд санаа зовох, хүч чадлаа хянах болон сэтгэл зүйн тогтворгүй байдлаа удирдан жолоодохтой холбоотой/ үүсч, улмаар үе тэнгийн хүүхдүүдтэй хамтран ажиллах, сургууль, боловсролын талаар эерэгээр сэтгэх, суралцах хувийн зохион байгуулалт, хөрвөх чадварт нь саад учруулж болзошгүй.

Энэ үед нь тэдэнд хичээл сургуулиар нь дамжуулан хорт зуршлаас хол хөндий байх, бусдын зүй бус нөлөөллөөс ангид байж, биеэ зөв авч явах, мансуурал, согтуурлын хор уршиг, үүсэх үр дагаврын болон эрх зүйн учир холбодлын талаар мэдлэг, боловсрол олгох шаардлагатай.

Бага, дунд сургуулийн танхимын сургалтаар хүүхдүүдийн хувь хүний болон нийгмийн харилцааны ур чадварыг дэмжсэнээр хожимын амьдралд нь мансуурал, бусдын зүй бус нөлөө, уруу таталтаас хол байлгах сэдэл, хандлагыг төлөвшүүлж болох тухай баримт материалыг тодорхой тайлбарласан байна. Мөн, энэхүү хөтөлбөрийн хүлээгдэн буй үр дүн нь сургууль завсардалтыг бууруулах, хичээл болон хичээлээс гадуур секц, дугуйланд хамрагдах зэрэг чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, сэтгэлгээ, хандлагын хувьд байнга өөрчлөгдөн буй хүрээлэн буй орчин, нийгмийн хөгжилтэй дасан зохицох, хорт зуршил, амьдралын хэвшлээс татгалзах болон мансууруулах, сэтгэгцэд нөлөөт бодисоос урьдчилан сэргийлэхэд хувь хүнд ач холбогдолтой нийгмийн харилцааны бусад ур чадваруудыг тэдэнд эзэмшүүлэх явдал болно. Танхимын сургалтын үед анхаарах ёстой зүйлүүдийн нэг нь ангийн хамт олны эв нэгдэл юм. Энэ нь бүх сурагчдад тааламжтай, суралцах, анхаарлаа төвлөрүүлэх боломжийг тэдэнд олгосон эерэг зөөлөн, айдасгүй, санаа зовох зүйлгүй байхыг ойлгоно.

Сургалтын энэхүү хөтөлбөрийг хүүхдийн нас, сэтэгхүйд тохирсон агуулга, хэлбэртэй байх шаардлагыг хангаж боловсрол, эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүйн халамж үйлчилгээ үзүүлдэг болон хууль сахиулах зэрэг төрийн, мөн хүүхдийн болон мансууруулах, сэтгэгцэд нөлөөт бодистой тэмцэх төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааны үр дүнд боловсруулан батлахаас гадна, багшлах хүний нөөцийг тусгайлан бэлтгэх шаардлагатай болно<sup>9</sup>.

Сургалтын арга барилын хувьд “*шавь төвтэй*” буюу суралцагсдаар өөрсдөөр нь тодорхой өгөгдөл, сэдвийн хүрээнд, хэлэлцүүлэг, мэтгэлцээн зохион байгуулах, олон талаас нь хэлэлцэх боломж, нөхцлийг бүрдүүлж өгөх байдлаар зохион байгуулна. Гол агуулга нь хүүхдүүдийн өдөр тутмын амьдралд тохиолдох эрсдэлтэй зан үйл, үйл явдалд зөв үнэлэлт дүгнэлт өгч, эрүүл, аюулгүй сонголт хийх боломжийг олж харах чадварыг тэдэнд олгоход чиглэгдэх бөгөөд нийгмийн хөгжлийн ерөнхий зүй тогтол, хүмүүсийн хандлага болон, сэтгэл зүй болон сэтгэл хөдлөлөө хянах чадварт суралцахад нь дэмжлэг болох учиртай. Нөгөөтэйгүүр, энэхүү хөтөлбөр хүүхдүүдэд сэдэл өгөх аливаа зүйлс, ялангуяа тодорхой төрлийн бодис, эмийн талаарх мэдээллийг агуулсан байх нь зохисгүй.

### **4.3 Өсвөр насныхныг мансуурлаас урьдчилан сэргийлэх**

Өсвөр насандаа хүн амьдралынхаа хөгжлийн хамгийн чухал үеийг туулах бөгөөд амьдралынхаа туршид хуримтлуулсан мэдлэг, мэдээлэл, туршлага нь зан төлөв, сэтгэлгээ болж төлөвших эгзэгтэй үе юм. Энэ үедээ насанд хүрсэн хүний үүрэг хариуцлагыг туршилтын журмаар хүлээж, дадал бий болгоно. Өөрөөр хэлбэл тэдний тархи, сэтгэхүй нь уян хатан, яг л насанд хүрсэн хүний тархи, сэтгэхүйн эрт үеийнх шиг байдаг онцлогтой. Энэхүү туршлага нь АНУ, Европ болон Австрали улсад өргөнөөр хэрэглэгддэг бөгөөд судалгааны тайлангууд<sup>10</sup> олон байдаг.

<sup>9</sup> Энэ талар АНУ, Канад, Шинэ Зеланд, Их Британи, Австрали зэрэг дэлхийн олон улс орнууд DARE (Drug Abuse Resistance Education) хөтөлбөрийг хэрэгжүүлж амжилтанд хүрч байгаа туршлага бий.

<sup>10</sup>16Bühler, 2008; Champion, 2012; Dobbins, 2008; Faggiano, 2005; Faggiano, 2008; Fletcher, 2008; Foxcroft, 2011; Gates, 2006; Jackson, 2012; Jones, 2006; Lemstra, 2010; McGrath, 2006; Moreira, 2009; Müller-Riemenschneider, 2008; Pan,

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх, автомашин жолоодохтой холбоотой эрсдэл бүхий зан үйл, согтууруулах ундаа, утаат тамхи хэрэглэх, сексийн эрсдэлтэй харилцаа, зан үйл зэрэг сөрөг хандлагуудад хариу үйлдэл үзүүлэх, зөв шийдвэр гаргахад тэдний уураг тархинд гарч буй чухал байж болох өөрчлөлтийн талаар мөн томчуудын үүрэг ролийн талаар бие даасан үнэлэлт, дүгнэлт өгөх явдал маш чухал юм.

Энэ насанд нь тэдэнд харилцааны ур чадвар, нийгмийн нөлөөллийн болон хувь хүний ур чадварт нь үндэслэгдсэн урьдчилан сэргийлэх боловсрол олгоход анхаарах ёстой.

Ур чадварт үндэлсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь тусгай бэлтгэгдсэн сургагч багш нар хүүхдүүдийн суралцах идэвхи чармайлтыг өдөөж, сургалтыг шавь төвтэй арга барилаар зохион байгуулж, тэдэнд хувь хүний ур чадвар, харилцааны соёл олгох зорилтыг хангахаас гадна хүүхдүүдэд үе тэнгийнхний зүй бус нөлөө, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээг дэмжих нийгмийн зүгээс ирэх даралт шахалтаас татгалзаж чаддаг байх ур чадварт сургах, амьдарлын ерөнхий хэмнэлийн хувьд эрүүл, аюулгүй сонголт хийхэд нь дэмжлэг үзүүлэх, биеэ авч явах соёлыг төлөвшүүлэхэд анхаарна.

Түүнчлэн хүүхдүүдийн нас, сэтэгхүйн онцлогт тохирсон хэлбэрээр мансуурах дон буюу түүнээс үүдэн гарах үр дагавар, эерэг сөрөг нөлөөлийн талаар нийгмийн нөхцөл байдал, хүмүүсийн хандлагын тухай хэлэлцүүлэг, мэтгэлцээн зохион байгуулах, нийгэм, ялангуяа хүүхдүүдийн дундах мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээний тогтсон хэвшил, түүнийг хүлээн зөвшөөрөх хандлагыг өөрчлөх шаардлага тавигдана. Энэ үед тэдний сэтгэл зүйд хүчтэй нөлөөлөх уг бодисын хэрэглээний үр дагавар /эрүүл мэнд, эрх зүй, эдийн засаг, нийгмийн сөрөг үр дагаварууд/-ыг харуулсан зурагт хуудас, дүрс бичлэгүүдийг сургалтанд нь ашиглаж байна, тухайлбал ОХУ.

#### ***4.4 Сургуулиудын соёл, дэг журмыг төлөвшүүлэх бодлого, үйл ажиллагаагаар дамжуулан урьдчилан сэргийлэх***

Сургуулиудын тогтсон соёл, уламжлал хүүхдүүдэд зан суртхуун төлөвшин тогтоход маш их нөлөөтэйг АНУ, Европ, Австрали, Ази, Латин Америкын болон Африкийн эрдэмтэд судлан тогтоосон<sup>11</sup> байдаг. Сургууль болон түүний орчимд сургалт, холбогдох бусад арга хэмжээний үед сурагчид болон багш, ажилчдын хэн аль нь ч мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис, бэлдмэл, тэр ч бүү хэл согтууруулах ундаа, утаат тамхи хэрэглэхийг хориглодог. Хорт зуршлыг үйлдэх, мансуурсан тохиолдлыг боловсрол, эрүүл мэндийг дэмжих нөхцөл байдалд хөрвүүлж, сургалтанд ашиглах бодлого баримталдаг. Сургуулийн бодлого, хэрэгжилт нь тэдний оролцоог хангах, суралцах боломжыг нэмэгдүүлэх, хичээл сургалттай холбоотой идэвхи, санаачлагыг нь хөхүүлэн дэмждэг байх ёстой. Энэ бол ерөнхий бодлого, үйл ажиллагаа юм, гэвч тодорхой тохиолдлуудад мансууралд автсан, эсвэл түүнтэй холбоотой бусад зүй бус зуршлаа хаях зорилготой хэн нэгэнд дэмжлэг үзүүлэх, туслах хүнийг томилох гэх мэт үйл ажиллагааг зохицуулсан байж болно. Сургуулийн энэхүү бодлого, уламжиллын хүрээнд ур чадварт үндэслэгдсэн боловсрол олгох эсвэл хүүхдийг сурган хүмүүжүүлэх ур чадварын сургалт, эцэг эхчүүдийн оролцоог хангах зэрэг урьдчилан сэргийлэх бусад бодлого, үйл ажиллагаатай хосолсон арга хэмжээ авч болно.

#### ***4.5 Архи, тамхины хэрэглээний талаарх бодлого, үйл ажиллагаа***

Архи тамхины хэрэглээ нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээнээс илүү түгээмэл бөгөөд тэр хэмжээгээрээ дэлхий даяар тэдгээртэй холбоотой өвчлөл, асуудал илүү байна. Архи, тамхийг өсвөр насандаа, тархины хөгжил ид эрчтэй явагдаж байх үедээ хэрэглэх нь амьдарлын дараа дараагийн үе шатуудад мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодист автах тэдгээрийг хэрэглэх явдалд шууд хамаарлаар нөлөөлнө. Түүнчлэн, уг бодисыг хэрэглэдэг залуус ихэнх тохиолдолд согтууруулах ундааны хэт их хэрэглээтэй байдаг мөн бусад бодисыг

---

2009; Porath-Waller, 2010; Ranney, 2006; Reavley, 2010; Roe, 2005; Schröer-Günther, 2011; Skara, 2003; Soole, 2008; Spoth, 2008; Thomas, 2006; Thomas, 2008; West, 2004; Wiehe, 2005.

<sup>11</sup> Fletcher, 2008; Moreira, 2009; Reavley, 2010; Thomas, 2008.

хослуулан хэрэглэх явдал ч нилээд түгээмэл. Тиймээс ерөнхийдөө, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисоос залуучуудыг урьдчилан сэргийлэхэд согтууруулах ундаа, утаат тамхины, ялангуяа хэт их хэрэглээнээс урьдчилан сэргийлэх явдал чухал ач холбогдолтой байдаг. Энэ нь магадгүй нийгмийн эрүүл мэндийн бодлогоос ч илүү чухал хүчин зүйл байж магадгүй. Согтууруулах ундааны хэрэглээнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар олон улсын түвшинд хийгдсэн судалгааны тайлан<sup>12</sup> байна.

#### **4.6 Олон нийтэд түшиглэсэн олон талт арга хэмжээ**

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээнээс урьдчилан сэргийлэх зорилгоор олон нийтийг тодорхой үйл ажиллагаанд татан оролцуулах, эвсэл нэгдэл байгуулах, хамтын ажиллагаатай бүлгэм бий болгох зэргээр хамтралжуулах явдал нь зорилгоо биелүүлэх төрөл бүрийн арга хэмжээг зохион байгуулах, тогтмолжуулахад чухал ач холбогдолтой. Зарим тохиолдолд хамтрал хүмүүсийн сайн дурын үндсэн дээр аяандаа бий болох явдал ч байдаг, гэхдээ, олныг хамарсан, томоохон хэмжээний хамтрал нь ерөнхийдөө, нотлох баримтанд үндэслэгдсэн урьдчилан сэргийлэх, нөлөөллийн бодлого, арга хэмжээг түгээн дэлгэрүүлэх, тогтвортой байдлыг нь урт удаан хугацаанд хангахад нийгмийн гишүүд, олон нийтэд санхүүгийн болон арга замын талаар зөвөлгөө, дэмжлэг үзүүлэх хөтөлбөр, үйл ажиллагааны үр дүн байдаг. Олон нийтэд түшиглэсэн арга хэмжээ нь олон талт, олон газар, нөхцөл байдалд хэрэгжүүлэх боломжтой /тухайлбал, сургууль, гэр бүл, хэвлэл мэдээлэл тэр ч бүү хэл хууль сахиулах ажиллагаанд ч хүртэл хэрэгжинэ/. Энэ туршлага нь АНУ болон Канад, Австрали зэрэг улс орнуудад амжилттай хэрэгжүүлж буй туршлагаудыг судласан, судалгааны тайлан, илтгэлүүд<sup>13</sup> байдаг.

#### **4.7 D.A.R.E /Drug Abuse Resistance Education/ хөтөлбөр**

НҮБ-ын олон улсын мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус хэрэглээнээс урьдчилан сэргийлэх стандартыг хэрэгжүүлж, олон улс орнууд “Мансууруулах бодисын хэрэглээ боловсролыг боомилно” нэртэй хөтөлбөр хэрэгжүүлж байна.

Энэ хөтөлбөр нь 1983 онд АНУ-ын Лос-Анжелес хотод хэрэгжиж эхэлсэн бөгөөд энэ нь хүүхдүүд болон өсвөр насны хүмүүсийг муу зуршлаас хол хөндий байх сэдлийг бий болгож, хандлагыг төлөвшүүлэх, бусдад уруу татагдахгүй байх чадвар олгох сургалт юм. Өдгөө тус улсын дунд болон ахлах сургуулийн 75 хувьд энэ хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаагаас гадна, бусад 52 оронд амжилттай хэрэгжүүлж, дэлхий даяар 36 сая хүүхэд /үүнээс 26 нь АНУ-ынх/ хамрагдаад байна.

*Зорилго* нь хүүхдүүдийг:

- Аливааг таних мэдэх, согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус хэрэглээтэй холбоотой бусдын дарамт, шахалтаас зайлсхийж, асуудлыг өөрийнхөө эрх ашгийн үүднээс шийдвэрлэх.
- Өөрийгөө үнэлэх үнэлэмжийг нэмэгдүүлэх.
- Өөртөө итгэх.
- Хэрэглээний эерэг хандлагыг төлөвшүүлэх.
- Сөргөлдөөнтэй байдлаас гарах арга зам, бухимдлаа тайлах ухаан.
- Эрсдэлийн үнэлгээ хийх, шийдвэр гаргах ур чадвар.
- Хүчирхийллийг намжаах, багасгах ур чадвар.
- Бусдыг өөртөө татах болон харилцааны ур чадвар.
- Гэмт бүлэг, бөөгнөрлийн нөлөөлөлд автахгүй байх хэвшилтэй болгоход чиглэгдэнэ.

Энэ хөтөлбөрийн хүрээнд сургагч цагдаагийн ажилтнууд нь тусгайлсан 80 цагийн сургалтад хамрагдсан байх ба сургалтаар “Хүүхдийн хөгжил”, “Танхимын сургалтын удирдлага зохион байгуулалт”, “Заах арга зүй” болон “Харилцааны ур чадвар” зэрэг хичээлийг судалсан байх

<sup>12</sup> Bühler, 2008; Callinan, 2010; Hopkins, 2001; Lovato, 2011; NCI, 2008; Ranney, 2006; Richardson, 2009; Stead, 2005; Thomas, 2008

<sup>13</sup> Bühler, 2008; Ferri, 2013, (in press); Hopkins, 2001; NCI, 2008; Ranney, 2006.

шаардлагатай. Түүнчлэн ахлах ангийн сурагчидтай ажиллах сургагч ажилтны хувьд нэмэлт 40 цагийн сургалтад хамрагдах ба тэд сургуулиудаар явж сурагчидтай уулзаж, ярилцах тэдэнтэй ажиллаж, дээр дурдсан мэдлэг чадваруудыг эзэмшүүлэх ба заавал багшлах эрхтэй байхыг шаардахгүй. Сургуулийн багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нартай хамтарч ажиллана.

2007 онд АНУ-д эмчийн зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүйгээр олгогддог эмийн хэрэглээний талаар уг сургалтын хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин боловсруулсан ба үүнд хууль сахиулагчид, эм зүйчид, лабораторийн ажилчид болон мэргэжлийн хяналтынхан, Мансууруулах бодисын эргэлтэд хяналт тавих үндэсний алба, Хар тамхитай тэмцэх алба, Хүнсний бүтээгдэхүүн хар тамхины хэрэглээг зохицуулах хяналтын алба, Хар тамхины хууль бус хэрэглээний хяналтын үндэсний институт, Мансууруулах бодисын хэрэглээ, сэтгэцийн эмгэг судлалын алба болон тус улсын холбогдох бусад байгууллага албан тушаалтнууд хамтран ажилласан. 2009 онд уг хөтөлбөрийн дунд ангийнхны сургалтын хөтөлбөрийг *keepin' it REAL*<sup>14</sup> нэртэйгээр дахин боловсронгуй болгож өөрчилсөн ба их дээд сургуулиудын туслалцаанд үндэслэжээ. Тусгай буюу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд сургалт зохион байгуулах зорилгоор цагдаагийн ажилтнуудыг 17 долоо хоногийн хугацаатай сургагч багшийн сургалтад хамруулдаг.

Үндэстнүүдийн болон хүмүүн хоорондын ойлголцол, харилцааны судлаач Майкел Л.Хечт болон Их Британы Уорвик их сургуулийн профессор Мишелл А.Миллер нар 2003 онд ерөнхий боловсролын 6000 сурагчдаас тэдгээрийн архи тамхи, мансууруулах бодисын хэрэглээний талаар санал асуулын хуудсаар судалгаа авсан бөгөөд судалгааны дүгнэлтээр *keepin' it REAL* хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийн хувьд дээрх зуршилд автах явдал хөтөлбөрт хамрагдаагүй хүүхдүүдээс бага байжээ. Бусдын нөлөөллөөс татгалзаж, эрүүл сонголтыг хийхдээ олон арга барилыг тэдгээр хүүхдүүд сонгосон нь ажиглагдаж байгаагаас гадна мансууруулах бодисын тухай ойлголт нь зөв, түүнээс хол хөндий байх сэтгэлгээ оюун ухаанд нь гүн бат суусан байдал ажиглагдсан тухай тайландаа тусгасан байдаг<sup>15</sup>. Уг төслийг архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэж үзсэн гэх 1300 сурагчдын дунд хэрэгжүүлж, үр дүнг нь тооцоход 72 хувийн эерэг үзүүлэлттэй байсан талаар 2006 оны өсвөр насны хүмүүсийн мансууруулах бодисын хэрэглээг бууруулах, хүрсэн төвшинг нь хадгалах боломжийг эрэлхийлсэн судалгааны тайлан<sup>16</sup>-д дурдсан байдаг.

#### **4.8 Эмчийн зөвшөөрлөөр олгох эмийн зүй бус хэрэглэхээс урьдчилан сэргийлэх**

НҮБ-ын конвенцын дагуу хяналтад байх болон эмчийн зөвшөөрлөөр олгох мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эмийн хууль бус хэрэглээ, эмийн сангуудаар зарагддаг, ердийн эмийг эрүүл мэндийн бус зорилгоор хэрэглэх явдал олон оронд асуудал болж, заримд нь “Зэрлэг олсны ургамал”-ын хууль бус хэрэглээний дараа, 2 дугаарт орж байна. Хойд Америкийн судлаачдын тогтоосноор Европ, Африк, Азийн өмнөд хэсгийн улс орнууд болон Латин Америкийн орнуудад эмчилгээний маш их хэрэгцээ байна. Улс орны нөхцөл байдал, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын төрөл зэргээс шалтгаалж ялангуяа, эмзэг бүлгийн хүмүүс /хүүхэд, өсвөр насныхан, эмэгтэйчүүд, хөгшчүүд, эрүүл мэндийн хаамжын мэргэжилтнүүд, гэр оронгүй, тэнэмэл хүүхдүүд, мөргөлдөөн, дайны дараах улс орнуудын цэргийн албан хаагчид иргэд гэх мэт/ өндөр эрсдэл дунд байна. Түүнчлэн, эмчийн зөвшөөрлөөр олгох эмийн хууль бус хэрэглээнээс үүсэх нийгэм, эрүүл мэндийн үр дагавар нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээний улмаас үүсэх үр дагавартай адилхан, хүнд байна.

Эмч, эмнэлгийн байгууллагын ажилтнуудад урьдчилан сэргийлэх ажлын талаар зөвлөх, түүнчлэн жор олгох явдлыг багасгах, хяналтыг сайжруулах, бүртгэлжүүлэх нь жор бичих замбараагүй явдлыг таслан зогсоох, өвчтөнүүдэд зөвхөн эмчилгээний зорилгоор тухайн эм, бэлдмэлүүдийг олгох явдалд ахиц гарна. Аав, ээж болон гэр бүлийн гишүүдийн эмчийн жороор

<sup>14</sup> Refuse/татгалзах, Explain/тайлбарлах, Avoid/зайлсхийх, Leave/орхих гэсэн үгийн товчлол

<sup>15</sup> <https://www.ncbi.nlm.nih.gov/pmc/articles/PMC2919767/>

<sup>16</sup> <https://real-prevention.com/wp-content/uploads/2016/05/Research-Studies.pdf>

олгох эмийн хэрэглээний талаарх мэдлэгийг нэмэгдүүлж, тэдгээр эмүүдийг зөвхөн эмчийн хяналтан дор хэрэглэхийн учир холбогдлыг ойлгуулах, анхааруулах нь хүүхдүүд, эсвэл гэр бүлийн аль нэг гишүүний эмийн зохистой хэрэглээнд тустайгаас гадна өөрсдөд нь ч гэсэн ач холбогдолтой байна. Энгийн хирнээ ач холбогдолтой байж болох арга нь хугацаа хэтэрсэн, ашиглалтаас гарсан эмийг зохих ёсоор нь устгаж сурах явдал юм.

#### **4.9 Олон улсын конвенцоор хориглоогүй сэтгэцэд нөлөөт бодис, эмийн зүй бус хэрэглээнээс урьдчилан сэргийлэх**

Дэлхийн олон улс орон НҮБ-ийн дурдсан конвенцуудад заагдаагүй сэтгэцэд нөлөөт эм, бэлдмэлийн хууль бус хэрэглээний асуудалтай байна, эдгээр эм бэлдмэлүүдийг “хуулийн өндөрлөг”, “ухаалаг бодис” гэж нэрлэдэг. Эдгээр эм, бэлдмэлүүдийн хууль бус хэрэглээний тухай ярихгүй байгаа бөгөөд тодорхой судалгаа ч хийгдээгүй байна. Энэхүү стандартад дурдагдсан урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээнүүд нь нэр бүхий, тодорхой бодисын талаар яриагүй, зөвхөн хүний амьдралын мөчлөгийн эрт үед тэдний эмзэг, тогтворгүй байдлыг илрүүлэн, цаашдын амьдралдаа сөрөг нөлөөлөл болох зан үйлийг, тухайлбал мансуурах, согтуурах зэрэг, бус эерэг нөлөө үзүүлэх зан үйлийг хэвшүүлэх нөхцөлийг бүрдүүлэх тухай юм. Тиймээс дурдсан арга хэмжээ, үйл ажиллагаа, бодлогыг энэ мэт сэтгэцэд нөлөөт бодис, эм, бэлдмэлүүдийн хууль бус хэрэглээнээс урьдчилан сэргийлэхэд ашиглах нь зарчмын хувьд гажихгүй байх талтай. Гэсэн ч энэ төрлийн бодис, эм, бэлдмэлүүдийг тусад нь судлан, зарим нэг онцлогуудыг тодорхойлох шаардлагатай.

#### **4.10 Дэмжлэг үзүүлэх бодлого, зохицуулах хүрээ, хязгаар**

Аливаа бодлого, үйл ажиллагаа хэзээ ч вакуум орчинд, бие даан оршин тогтнох боломжгүй юм. Өмнө нь танилцуулснаар, эрүүл мэндийн төв тогтолцооны нэг хэсэг нь болсон мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисоос урьдчилан сэргийлэх ажилд анагаах болон судалгаа, шинжилгээний зорилгоор тэдгээрийг ашиглах тохиолдол байдаг. Энэ нь тухайн бодис болон хамаарал бүхий бусад эм, бэлдмэлүүдийн нийлэгжилт, улам боловсронгуй болж, чанар, хэлбэр дүрс, хэмжээгээ өөрчлөх болон тэдгээрийн хууль бус хэрэглээнээс урьдчилан сэргийлж, эрүүл, аюулгүй байдлыг хангах үүрэг зорилгод нь харшлахгүй. Дурдсан зүйлүүдийг тооцсон, үр дүнтэй, ашигт үйлийн коэффициент өндөр үндэсний систем бүрэлдэх нөхцөл байдлуудыг доорх байдлаар дурдаж болно. Үүнд:

- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хэтрүүлэн хэрэглэх, ДОХ болон Гепатит С вирусийн халдвар дамжих гэх мэт мансууралтай холбоотой нийгэм, эрүүл мэндийн үр дагавраас урьдчилан сэргийлэх, энэ бодисоос хараат болсон өвчтөнүүдийг анхаарч эмчлэх, нөхөн сэргээх, нийлүүлэлтийг бууруулах (нөгөө талдаа хэрэгцээг бууруулах) зэрэг мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хөгжил, улам боловсронгуй болох үйл явц, тэдгээрийн хэрэглээтэй холбоотой нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэхийн тулд тэдгээр бодисыг анагаах ухаан, судалгаа шинжилгээний зорилгоор ашиглах, туршилт хийх хяналт, эрүүл мэндийн иж бүрэн, төвлөрсөн системийг бүрдүүлэх,

- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисоос хараат болох нь маш ужиг, сэтгэцийн тогтворгүй байдал нь байнга эргэн сэдрэх эрсдэлтэй, улмаар хүрээлэн буй орчны нөлөөгөөр уураг тархинд сэтгэцийн, биологийн болон генийн цогц, эмзэг, тогтворгүй байдлыг үүсгэнэ. Ийм хүнийг яллах бус эмчлэх шаардлагатай гэдгийг нийтээрээ хүлээн зөвшөөрөх,

- Мансуурал, согтуурлаас урьдчилан сэргийлэх, мансуурагч, донтогч нарыг нөхөн сэргээх эмчилгээнд хамруулах, түүнчлэн эрсдэлтэй, эрүүл бус бусад зан үйлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, үйл ажиллагааны хөтөлбөрийг багтаасан хүүхэд, өсвөр насныхан болон насанд хүрэгчдийн эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлэх нийгмийн эрүүл мэндийн бусад арга хэмжээ, төсөл, хөтөлбөрүүдтэй үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах зэрэг болно.

*Түүнчлэн, төрийн болон төрийн бус байгууллагаас хэрэжүүлэх аливаа арга хэмжээ нь зохих журам, зохицуулалттай байвал үр дүн нь илүү сайн байх дараах эрх зүйн хэм хэмжээг батлан мөрдүүлэх шаардлагатай. Үүнд:*

- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үндэсний стандарт,



- Уг бодисоос урьдчилан сэргийлэх үндэсний эмч, хуульчдын мэргэжлийн үйл ажиллагааны стандарт,
- Сургуулиудын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд мансуурал, согтуурлаас урьдчилан сэргийлэх, суралцагсдыг хорт зуршилгүй байлгах зан үйлд сурган боловсруулах бодлого, дээрх зорилгыг хангасан эрүүл мэнд, нийгмийн харилцааны суурь боловсролыг иргэн бүрд хүргэх, хувь хүнийг хөгжүүлэх бодлого, арга хэмжээний хөтөлбөр/төслүүд буюу тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлэх арга зам, стандартууд,
- Ажил олгогч эздийн холбоонуудад ажлын байранд мансуурах, согтуурахаас урьдчилан сэргийлэх хөтөлбөр/төлөвлөгөөг, хэрхэн хэрэгжүүлэх арга зам, стандартуудтай нь батлан мөрдүүлэх талаар шахалт үзүүлж, шаардлага, шалгуур тавих бодлого, стратегийн баримт бичиг,
- Айл өрх, гэр бүлийг хүүхдийг гэр бүлийн орчинд сурган боловсруулах, анхаарал халамж тавих, бие болон сэтгэл зүйн зөв төлөвшилтийг бий болгоход эцэг эх, гэр бүлийн бусад гишүүдэд дэмжлэг үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээний талаарх бодлогын баримт бичиг, стандарт,
- Нийт болон тодорхой нутаг дэвсгэрийн хэмжээнд сан бүрдүүлж мониторинг, хяналт шинжилгээг тогтмол хийж бодлого боловсруулагчид, хуульчид болон судлаачдыг дүн шинжилгээ хийсэн мэдээллээр /энэ нь нийгэмд өргөн хэрэглэж буй, эсвэл шинээр гарч ирсэн мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис болон хэрэглээний шинэ аргууд, шинээр бий болж буй хүүхэд, хүмүүсийн үе, бүлэг, анги давхарга гэх мэт/ хангах, түүнчлэн урьдчилан сэргийлэх ажил болон нөхөн сэргээх эмчилгээнд ач холбогдолтой мэдээллийг боловсруулах, дүн шинжилгээ хийх явдлыг тогтмолжуулах талаар журамлаж өгөх нь зүйтэй.

#### **4.11 Судалгаа, шинжлэх ухааны нотолгоонд үндэслэсэн нөхцөл байдал**

Урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцооны үр дүнтэй, бодит байх нь шинжлэх ухаан, судалгааны баримт, материалд, аль алинд нь үндэслэгдэх явдал юм. Харгалзан үзэх 2 хүчин зүйл бий. Үүнд:

- Нэг талаас нөхцөл байдлыг бодитоор тодорхойлсон, тодорхой мэдлэг, ойлголтод үндэслэн нөлөөллийн бодлого, арга хэмжээг авна. Энэ нь эмзэг, тогтворгүй өөрөөр хэлбэл анхаарал татсан эсвэл мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэж эхэлж буй хүмүүсийг тогтоож тэдний хэрэглээний шалтгаан, түүнийг арилгах нөлөөллийн ямар бодлого, арга хэмжээг хэрхэн, яаж авахыг тодорхойлно.

- Нөгөө талаас, үр дүн, үр нөлөөг нь сайтар бодож, бүх хүчин зүйлсийг тооцож, төлөвлөсөн байвал зохино. Үр нөлөөг тооцохдоо боломжтой бүх тохиолдолд уг арга хэмжээ, бодлогыг хэрэгжүүлэхэд зарцуулах хөрөнгийн эдийн засгийн үнэлгээ, хэмнэлт зэргийг тооцож гаргасан байна.

Үр дүнгийн талаарх бүх хүчин зүйлсийг тооцсон тооцоолол нь бодлого тодорхойлогч, шийдвэр гаргагчдад ямар арга хэмжээг, хэдий хугацаанд авч хэрэгжүүлэх, ямар үр дүнд зорьж байгаа, ямар ямар эрсдэл учирч болох, тэдгээрийг хэрхэн яаж даван туулах, түүний үр дүнд мансуурлын төвшин хэдэн хувь, нэгжээр буурах эсвэл хүмүүсийн урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлага хэрхэн яаж өөрчлөгдөх талаар ойлгоход нь туслахаас гадна шийдвэр гаргахад нь нөлөөлнө. Түүнчлэн уг судалгаа, түүний үр дүн нь бусдад ойлгомжтой, тодорхой асуудлаар хэлэлцүүлэг, маргаан өрнүүлэх улмаар улам илүү боломж, нөхцөлүүдийг илрүүлэхэд ач холбогдолтой байвал зохино.

#### **4.12 Хэвлэл мэдээлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлийг ашиглах**

Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өнөөгийн хүрсэн төвшнөөрөө бодлого тодорхойлогчдын боловсруулсан бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөгөө олон хүн түргэн шуурхай хүргэхэд чухал ач холбогдолтой. Тиймээс мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээнээс урьдчилан сэргийлэх ажилд ч гэсэн тэдгээрийг хэрэглэх нь зүйтэй. Харин мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисоос урьдчилан сэргийлэх, хор хөнөөлийг нь сурталчилсан ямар мэдээллийг, ямар арга хэлбэрээр, хэдийд түгээх вэ? гэдгийг сайтар боловсруулж, тал бүрээс нь үнэлж, дүгнэсний үндсэн дээр шийдвэрлэх шаардлагатай. Энэ ажилд мөн л хамаарал бүхий субъектүүдийн хамтын ажиллагаа, оролцоо чухал ач холбогдолтой байна.

## 5.1 Нэгдсэн дүгнэлт

Монгол Улс мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой тэмцэх ажлыг олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө, олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр хүлээсэн үүргээ тодорхой хэмжээнд гүйцэтгэж байгаа ба урьдчилан сэргийлэх чиглэлээр сүүлийн 5 жилд 8 аймгийн 1497.8 га талбай канаабис буюу зэрлэг олсны ургамлын устгал хийсэн, мөрдөн шалгах ажлыг хийж байгаа хэдий ч хүүхэд, өсвөр үеийнхнийг энэ төрлийн бодист автах, гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор 1200 сурагч, 900 орчим оюутан, ШШГЕГ-ын болон орон нутаг дахь цагдаагийн байгууллагуудын нийт 600 орчим /давхардсан тоогоор/ алба хаагчдад энэ төрлийн бодисын хор хөнөөл, үр дагаврын талаар сургалт, соён гэгээрүүлэх ажил зохион байгуулсан.

Түүнчлэн “Хар тамхитай тэмцэх алба” нэртэй фэйсбүүк цахим хаяг шинээр нээж хар тамхи, мансууруулах бодисын хор уршгийг иргэдэд таниулах, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхэд, залуучуудыг сэрэмжлүүлэх зорилго бүхий 91 мэдээлэл, 56 зурагт хуудас, 20 нийтлэл, 45 видео бичлэгийг оруулан иргэдээс 13 санал санаачлагыг хүлээн авч ажиллаж байгаа ба уг Facebook-т 9400 хүүхэд хандаад байна. Түүнчлэн уулзалт, зөвлөгөөн, явган аялал, телевизийн шууд болон хөтөлбөрт эфирээр хэлэлцүүлэг, мэтгэлцээнийг Хар тамхитай тэмцэх газраас зохион байгуулах ажил тогтмолжсон боловч бидний үйл ажиллагаа судалгаа, шинжлэх ухааны үндэслэл бүхий баримт, мэдээлэлд тулгуурлахгүй байна. НҮБ-аас гаргасан стандартаар аливаа үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ судалгаа, шинжлэх ухааны үндэслэл бүхий баримт материалд үндэслэн боловсруулах бөгөөд гарч болох эерэг, сөрөг үр дагаврыг аль алиныг нь урьдчилан тооцох шаардлага тавигддаг. Цаашид энэ шаардлагыг хангаж ажиллах нь зүйтэй.

Судалгаагаар хүүхэд, өсвөр үеийнхний дунд ерөнхий үзүүлэлтийн хувьд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодист автах дараах эрсдэлүүд тогтоогдлоо. Үүнд:

**1. Цэгцтэй, нэгдсэн мэдээлэл, мэдлэг хомс байна:** Хүүхэд, өсвөр насныхны энэ төрлийн бодис, эм бэлдмэлийн талаар телевиз, радио, интернет, кино зэрэг эх сурвалжуудаас авч байгаа бөгөөд судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 96 орчим хувь нь /график 4, 17, 18/ энэ төрлийн бодисын тухай тодорхой хэмжээний мэдээлэлтэй, түүнчлэн 2004 оноос 2015 он хүртэл хугацаанд ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт “Эрүүл мэнд” гэсэн бие даасан хичээлээр хорт зуршил, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисоос ангид байх, тэдгээрийн хор хөнөөлийн талаар сурагчдад хичээл ордог байсан /одоо хасагдсан/ боловч түүнээс хэрхэн яаж урьдчилан сэргийлэх, ялангуяа хүүхдүүдийн хувьд ямар хор уршигтай талаар мэдлэг, мэдээлэл хангалтгүй байгаагаас гадна бусдын зүй бус нөлөөллөөс хэрхэн ангид байх чадвар муу байна /график 5, 6, 26/. Энэ нь нэг талаасаа сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, агуулга, цаг сэдвийн асуудал байгаа боловч нөгөө талдаа сургагч багш нарын энэ төрлийн бодис, урьдчилан сэргийлэх арга замын талаар мэдлэг, чадвар хомс байгааг илтгэнэ (энэ талаар дунд сургуулийн 12 багш, нийгмийн ажилтнуудтай уулзах үед тогтоогдсон).

Мөн энэ төрлийн гэмт хэрэгт ял шийтгэгдсэн хүмүүсийн ярианаас дунд сургуульд суралцаж байхдаа уг бодисоос урьдчилан сэргийлэх, хор хөнөөл, үр дагаврын талаар огт мэддэггүй байсан ба сургалтаар хичээл орж байсныг санахгүй, эсвэл тийм хичээл орж байгаагүй, орж байсан ч юу ойлгож авснаа мэдэхгүй байна гэж тайлбарлаж /график 57/ байсан нь дээрх нөхцөл байдал сургалтын тоон болон чанарын үзүүлэлт хангалтгүй, улмаар нийтээрээ ойлголт муутай байгааг илэрхийлэх баталгаа болохоос гадна хүүхдүүд, ялтнууд аль аль нь энэ төрлийн бодисыг анх сонирхож, бусдыг даган дуурайж хэрэглэсэн /график 12 ба 50/ гэж хариулснаас үзэхэд эрсдэл бүхий нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгч, зөв шийдвэр гаргах чадваргүй, сэтгэлийн хөөрлөөр асуудалд ханддаг нь харагдаж байна /ийм ур чадварыг сургалтаар олгохгүй байна/.

Мөн, энд харгалзах зайлшгүй нэг хүчин зүйл байгаа нь хууль сахиулах, шүүх, прокурор, өмгөөллийн болон холбогдох бусад байгууллагууд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис, түүнтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх талаар нэгдсэн бодлого, мэдлэг, мэдээлэлгүй байгаа явдал. Өөрөөр хэлбэл эдгээр байгууллагуудын хамтын ажиллагаа, ойлголцол дутмаг байгаа нь асуудлыг шийдвэрлэхэд зохих хэмжээгээр нөлөөлж байна гэж үзнэ. Тэмцэх гэж байгаа зүйлийнхээ талаар буюу тэмцлийн арга, үйл ажиллагааны талаарх нэгдмэл, цэгцтэй ойлголт нь тэмцлийн эхний бөгөөд чухал хүчин зүйл гэдэг энгийн зарчимд

бидний үйл ажиллагаа үндэслэгдэх ёстой. Энэхүү хамтын ажиллагааны дутагдалтай байдлын талаар ЦЕГ-ын даргын хэлсэн үгэнд тодорхой дурдагдсан байна<sup>17</sup>.

**2. Эрүүгийн эрх зүйн бодлого алдагдсан:** Манай улсын эрүүгийн эрх зүйн тогтолцоонд хүүхэд, өсвөр насныхныг халамжилсан бодлого байдаг хэдий ч мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдсон эсвэл гэмт этгээдүүдэд ашиглагдсан тохиолдолд онцгойлон үзэх зохицуулалт, Эрүүгийн хуулийн тусгай ангид байхгүй. Мөн энэ төрлийн гэмт явдлыг саармагжуулах, донтогч нарыг эмчлэх, нийгэмшүүлэх цогц арга хэмжээ манай улсад байхгүй нь эрсдэл дагуулж болзошгүй байна. Тухайлбал: Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ бус ял шийтгэх замаар хууль, эрх зүйн зохицуулалт хийгджээ. Шинэ хуучин хуулиудын хооронд үүссэн хорих ял оногдуулах хугацааны сул орон зайг эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээгээр нөхөж, мансуурагч, донтогчдыг эмчлэх байр, техник хэрэгсэл, орчин нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай байсан. Иймд төрийн бус байгууллагуудын идэвх санаачлалыг дэмжиж донтогч, хэрэглэгчийг эмчлэх, сэтгэл засал хийх арга хэмжээг төрөөс санхүүжүүлэх хэрэгтэй байна. Хууль сахиулахын их сургуульд хийгдсэн судалгааны тайланд дурдсан “Бөмбөлгийн нөлөөний онол”-оор “*нэг газар мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой хатуу тэмцсэнээр түүнийг нийлүүлэлтийг тогтвортой бууруулж, барьж чадахгүй бөгөөд тухайн үйл явц нь тэмцлийн эрч сул, нөгөө хэсэг рүү шилжих*” процесс юм. БНХАУ-ын эрүүгийн хуулинд заасан энэ төрлийн гэмт хэрэгт оногдуулах ялын бодлого чанга, цаазаар авах хүртэл ялтай. ОХУ-ын эрүүгийн хуулиар НҮБ-ын конвенцод заасан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисоос гадна түүнтэй адилтгах бусад бодисыг хууль бус гэж үзэж ял оногдуулах бодлого барьж байгаа нь асуудлыг өргөн хүрээнд харж, шийдвэрлэсэн нь дээрх онолын үндэслэлээр манай улсад эрсдэлийг үүсгэж болзошгүй.

**3. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын тэлэлт:** Судалгаанд хамрагдсан ялтнуудын санал асуулгын хуудас бөглөсөн, ярилцлагын үед хийсэн тайлбар зэргээс харахад энэ төрлийн бодисын хэрэглээ, түүнд автах явдал хүний хөрөнгө чинээ, гарал үүсэл, нийгэмд эзлэх байр суурь, боловсролоос үл хамаарч нийтлэгшиж байна /график 41, 46, 47/. Түүнчлэн гэр бүл, хүрээлэн буй орчны хэвийн уур амьсгал дунд өсөж, бойжсон хүүхдүүд ч насанд хүрсэн хойноо уг бодисын хэрэглээтэй болох явдал жирийн үзэгдэл болсон бөгөөд энэ нь судалгаанд оролцсон ялтнуудын олонх нь гэр бүлийн өссөн, хүмүүжсэн орчин нь хэвийн байсан гэж хариулснаас харагдана /график 58/. Өөрөөр хэлбэл нийгмийн гарал үүсэл, орчин мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээнд нөлөөлөх гол хүчин зүйл биш болохыг харуулна. Орчин үеийн нийгмийн хөгжлийг дагаад мансуурах олон сонголттой болсон. Энгийн цавуу, ахуйн хэрэглээний хий/гааз зэрэг бодисоос лабораторийн аргаар, нийлэгжүүлж гарган авсан амфетамин, метамфетамин төрлийн мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис, ургамлыг хэрэглэх бодит нөхцөл бий болсон байна. Судалгаанд хамрагдсан сурагчдын үзэж байгаагаар мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хэрэглээ хүүхэд, өсвөр үеийнхний дунд түгээмэл байгаагаас /график 20/ гадна хэрэглэгдэж буй бодисын 15 (хэдийгээр бүрэн биш нэршил заасан ч) төрлийг нэрлэсэн, мөн судалгаанд оролцогч хүүхдүүдийн 26% нь энэ төрлийн бодисыг нэг удаагаас олон удаагийн давтамжтай хэрэглэж үзсэн нь анхаарал татаж байна /график 9/. Энэ төрлийн бодисын хэрэглээний индексийг, 1000 хүүхдэд 260 гэж үзвэл, улсын хэмжээнд 550 000 сурагч<sup>18</sup> байна гэж тооцоход, түүнд харгалзах индекс 143 000 байна. Өөрөөр хэлбэл (сургууль завсардсан хүүхдүүдийг тооцохгүйгээр) энэ хэмжээний мансуурагч, гэмт хэрэгтэн, хэрэглэгчид бидний дунд өсөж бойжиж байна гэсэн үг. Энэ нь ойрын 8-10 жилд тухайн хүүхдүүд эрх зүйн чадвар, чадамжтай болж, нийгмийн болон эрх зүйн харилцаанд бие даан оролцох үед үр дүн нь бодитоор илэрч, нөхцөл байдалд нөлөөлнө гэсэн үг юм.

Ялтнуудын хувьд ч гэсэн, зэрлэг олсны ургамал татах, хэрэглэх явдал нийтлэг байсан бол сүүлийн үед Мөс, боловсруулсан Зэрлэг олс буюу Шавар, Гашиш, LSD болон Экстази, Героин, Кокаин гэх мэт бодисын нэр төрөл, чанар нэмэгдэж байгаа талаар ярьж байсан /график 51-д 11 төрлийн бодистой холбоотойгоор ял шийтгэгдсэн болохыг харуулсан/.

Түүнчлэн уг бодисын насанд хүрсэн хэрэглэгчдийн /судалгаанд хамрагдагчдаас гадна/ асуудал анхаарал татаж байна. Өнөөг хүртэл хэрэглэгчдийн талаар бүрэн судалгаа байхгүй. Эрүүгийн цагдаагийн албанаас ирүүлсэн тайлбараар манай улсад 5000-7000 мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэгч байна гэх боловч энэхүү судалгаанд хамрагдсан ялтнуудын үзэж байгаагаар нэг хүн дунджаар 30-40 хэрэглэгчийг мэддэг гэж

<sup>17</sup> “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэхэд талуудын оролцоог хангах нь” нэртэй чуулганыг төрийн ордонд зохион байгуулах үеэр танилцуулсан илтгэл, 2017 он.

<sup>18</sup> Монголын сурагчдын холбооноос гаргасан тоо

тооцвол 1000 гаруй хэрэглэгч байх тооцоо гарч байна. Энэ нь манай улсын нийт хүн амтай харьцуулахад бага биш байж болох юм.

Өнөөдрийг хүртэл Монгол Улсын Гаальд энэ төрлийн хэрэг, зөрчилтэй тэмцэх тусгай чиг үүрэг бүхий нэгж байдаггүй, техник хэрэгсэл, хүний нөөцийн мэдлэг, дадлага, чадвар хангалтгүй тухай 2017 онд төрийн ордонд зохион байгуулсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд талуудын оролцоог хангах нь” нэртэй чуулганы үеэр тус байгууллагын алба хаагчдын танилцуулга, гаргасан санал, хүсэлт байдаг. Энэ байдал нь уг бодисын тархалт, хэрэглээнд тодорхой хэмжээгээр нөлөөлнө гэж үзэж байна.

Энэ төрлийн гэмт хэргийн өсөлтийг жилд дунджаар 21 нэгжээр өсөх буюу 2030 онд 2016 оныхоос 4 дахин өсөх, өөрөөр хэлбэл 400 нэгж хүрнэ<sup>19</sup> гэсэн судалгааны тайлан, төсөөлөл байдаг.

**Шалтгаан, нөхцлийн талаар:** Хэдийгээр энэхүү судалгаа нь хүүхэд, өсвөр насныхны мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодист автах/хэрэглэх эрсдэлийг тогтоох зорилготой байсан ч шалтгаан нөхцлийн талаар зарим зүйлийг тодорхойлсон. Эдгээр нь эрсдэл хэмээн нэрлэгдэж, өмнө дурдсан хүчин зүйлүүдтэй агуулгын хувьд давхцаж болно. Дараах шалтгаан, нөхцлүүд тогтоогдсон. Үүнд:

- Ямар шалтгаанаар уг бодисыг хэрэглэж байгаа талаар сурагчид /график 26/, яагаад уг бодистой холбогдож, гэмт хэрэг үйлдсэн талаар ялтнуудын /график 50/ асуултад хариулсан байдлыг дүгнэвэл хувийн сонирхолдоо автах болон бусдыг дуурайж хэрэглэх явдал нийтлэг, өөрөөр хэлбэл хувийн сонирхолдоо хэт хөтлөгдөх, бусдыг даган дуурайх сэдэл нь үндсэн шалтгаан болж байна, түүнчлэн,

- Эрүүгийн цагдаагийн албанаас ирүүлсэн тайланд дурдсанаар БНХАУ, ОХУ болон Зүүн Өмнөд Азийн орнуудаас 3 чиглэлээр мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис импортлогдож байна. Харин манай улсын Гаалийн газарт энэ төрлийн бодистой тэмцэх тусгайлсан чиг үүрэгтэй нэгж байдаггүй, тоног төхөөрөмжийн хангалт муу,

- Шүүхийн шинжилгээний алба, цагдаагийн байгууллагад ашиглаж буй шинжилгээний техник хэрэгсэл, урвалж бодисууд нь орчин үеийн шаардлагын төвшинд хүрэхгүй байгаа ба энэ төрлийн бодис агуулсан ургамал, биологийн гаралтай зүйлийг шинжилж чадахгүй байгаа (тухайлбал, Нангиад зээргэнийг шинжилж, түүний үндсэн алкалойд болох Эфедринийг тодорхойлж чадахгүй байгаа),

- БНХАУ-ын Эрээн хотын Гаалийн цагдаагийн газар, Эрүүгийн цагдаагийн албаны ирүүлсэн тайланд дурдагдсанаар сард 4, жилд 48 тэр бум төгрөгийн үнэ бүхий мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис манай улсад импортлогдож байгаа нь эдийн засгийн асар их сонирхол гэмт хэргийн шалтгаан болох бүрэн үндэстэй юм. Хямд төсөр аргаар мөнгө олох хүсэлтэй олон иргэд энэ төрлийн бодисын олон улс дамнасан тээвэрлэгч болж байгаа тохиолдол цөөнгүй (тухайлбал, Монгол Улсын иргэд болох Хулан, Халиун нарт холбогдох эрүүгийн .....тоот хэрэг) байна. Үүний нэг баталгаа нь өнөөдрийн байдлаар БНХАУ, ОХУ болон Сингапур улсуудад энэ төрлийн гэмт хэрэгт манай 42 иргэн баривчлагдан, шалгагдаж байна,

- Манай улсын хууль сахиулах, шүүх прокурор, өмгөөллийн болон хамаарах бусад байгууллага, аж ахуйн нэгжүүдийн хамтын ажиллагааны дутагдалтай байдал, энэ талаар нэгдсэн ойлголтгүй зэрэг нь шалтгаан, нөхцлүүдийг дурдаж болно.

## **5.2 Санал, зөвлөмж**

### **5.2.1 Санал**

Судалгааны тайланд үндэслэн үндсэн 2 зүйлийг санал болгоно. Үүнд:

1. Энэ төрлийн бодисоос хүүхэд, өсвөр үеийнхэнд уг бодисын хор уршиг, эдийн засаг, нийгэм, эрх зүйн үр дагаврын болон бусдын зүй бус нөлөөллөөс ангид байх чадварыг сургалтаар дамжуулан олгох зорилгыг хангахын тулд сургалтын хөтөлбөр, агуулга, стандартыг НҮБ-ын олон улсын стандартад нийцүүлэн, бусад орны туршлагын дагуу /DARE хөтөлбөр/

<sup>19</sup> ХСИС-ын 2017 онд хийсэн судалгааны тайлан, 20 дугаар тал

батлан мөрдүүлэх.Энэ хөтөлбөрийн хүрээнд сургагч багш болон сурагчдыг сурган боловсруулах тухай асуудлыг аль алиныг нь шийдвэрлэнэ.

2. Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах, тухайлбал:

- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдсон хүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авах заалтыг тусгай ангийн энэ төрлийн гэмт хэргийг зүйлчлэх зүйл хэсэгт оруулах,

- Худалдах, өгөх гэсэн тусдаа ойлголт бүхий заалтыг /Эрүүгийн хуулийн 20.7-д буй/ өмнө мөрдөж байсан Улсын дээд шүүхийн тогтоолоор тайлбарласан ойлголтонд нийцүүлж “борлуулах” гэсэн нэг ойлголтоор тодорхойлох,

- Үзэл баримтлалын хувьд хүүхэд, өсвөр насныхныг энэ төрлийн гэмт хэрэг үйлдэхдээ хүч хэрэглэх, хуурч мэхлэх болон бусад байдлаар ашигласан тохиолдлыг хүндрүүлэх нөхцөл байдал гэж үзэх талаар зүйл ангиудад тодорхойлох зэрэг болно.

### 5.2.2 Зөвлөмж

Нэгдүгээр саналыг хэрэгжүүлэх зорилгоор дараах зөвлөмжийг хүргэж байна. Үүнд:

#### 5.2.1 Бүх нийтийн оролцоог хангах

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисоос урьдчилан сэргийлэх үндэсний стратегийн гол зорилго нь олон нийтэд, ялангуяа хүүхэд, өсвөр насныханд нийгмийн бүхий л салбарт, төвшинд эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэхэд орших бөгөөд энэ үйл хэрэгт бүх нийтийн оролцоог хангах нь чухал юм. Ингэхдээ хэн ямар төвшинд ямар үүрэг хариуцлага хүлээх, юу хийх болон юу хийж болохгүй, юуг анхаарах зэрэг асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай бүх хүчин зүйлийг тооцож, нийтэд ойлгомжтой байхыг анхаарах ёстой. Өөрөөр хэлбэл “**нэгдсэн ойлголт**” хамгийн чухал хүчин зүйл болно.

Тиймээс үндэсний стандарт/стратегийг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, үр дүнг тооцохдоо боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, мэргэжлийн хяналт, шүүх, прокурор, хууль сахиулах, нийгмийн халамж, үйлчилгээ, үйлдвэрчний эвлэл, хүүхэд залуучуудын байгууллагууд болон төрийн бус холбогдох байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагааг хангах явдал чухал ач холбогдолтой. Дараах зүйлүүдийг анхаарч ажиллана. Үүнд:

- Хэрэгжүүлэх ажлыг: Үндэсний, бүс нутгийн, тодорхой нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгжийн хэмжээнд хамаарал бүхий субъектүүдийн үйл ажиллагааны интегралчлал /харилцан бие биедээ үндэслэх, түүнээсээ шалтгаалах нөхцөл байдал/, түүний зохион байгуулалтыг хангана,

- Гол оролцогч, хамаарал бүхий субъектүүд: Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдах болон гүйцэтгэх байгууллага, албан тушаалтан, төрийн үйлчилгээг олон нийтэд хүргэх эрх, үүргийг хэрэгжүүлэгчид, төрийн бус болон шашны байгууллага, нийгмийн гишүүд болон тэргүүлэгчид, их дээд сургууль коллежууд, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд болон хамаарал бүхий бусад субъектүүдийг ойлгоно.

- Оролцогчид, хамаарал бүхий субъектүүдийн эрх, үүргийг тодорхойлох: Стратегийг хэрэгжүүлэх үед олон төвшинд, харилцан адилгүй бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай болно, тиймээс түүнийг амжилттай хэрэгжүүлж, үр дүнг нь үнэлэхэд эрх, үүрэг, хариуцлагын тодорхой байдал чухал ач холбогдолтойгоос гадна оролцогчдын үйл ажиллагааны идэвхжлийг хангана.

- Тэргүүлэх үүрэг гүйцэтгэгч болон зохион байгуулагчдыг тодорхой заасан байна.

#### 5.2.2 Урьдчилан сэргийлэх тогтолцоо үр нөлөөтэй байх шалгуур

Үр нөлөөтэй үндэсний хэмжээний урьдчилан сэргийлэх тогтолцоо нь шинжлэх ухааны үндэслэлтэй хэд хэдэн цогц арга хэмжээг өөртөө агуулна. Өөрөөр хэлбэл бодлого, арга хэмжээ бүр нь хүний нас, эрсдэлийн төвшин, бүлгээр нь хэд хэд ангилж, тус бүрд нь тохирсон бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх явдал чухал юм. Ингэхдээ бүлэглэсэн хэсгийнхэнд зориулсан ажил, арга хэмжээ, хэрэгжих үйл явц зэрэг нь хоорондоо шалтгаант холбоотой, бүхлээрээ нэгдмэл/цогц шинж чанартай /хүүхэд, өсвөр болон идэр насныхан, насанд хүрэгчдийн гэсэн ангилал нь ерөнхий бүтцээрээ нэгдмэл байх/, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх болон бусад эрсдэл бүхий зан үйлд өртөх эмзэг тогтворгүй байдалд нь чиглэсэн байна. Энэ нь мэдээж бодлого, үйл ажиллагааг хослуулан, зэрэгцүүлэн явуулахаас шууд хамаарах бөгөөд

арга хэмжээг нэг нэгээр бус цогцоор нь авч хэрэгжүүлэхийг шаардана. Бидний эцсийн зорилго нэгдмэл ба хүмүүст эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэн өгөх явдал гэдгийг байнга санаж байх хэрэгтэй.

Хоорондоо шалтгаант холбоо бүхий олон талт нөлөөллийн арга хэмжээ, бодлогыг хэрэгжүүлэхэд зохион байгуулалттай, сайтар бодож боловсруулсан төлөвлөгөө шаардлагатай, үүнд дараах хүчин зүйлүүдийг тооцсон байвал зохино, тухайлбал:

- Хамтран хэрэгжүүлэх бодлого, харгалзан үзэх хууль, эрх зүйн хэм хэмжээ,
- Шинжлэх ухааны үндэслэл, судалгаа баримтад тулгуурласан байдал,
- Үндэсний, бүс нутгийн болон тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд зохион байгуулах, өөрөөр хэлбэл үйл ажиллагааны төвшин, зохион байгуулалтын аргачлалыг тодорхойлсон байдал,
- Шийдвэр гаргагч, оролцогчдыг сурган боловсруулсан байдал болон
- Тогтолцооны үйл ажиллагаа, ашигт үйлийн коэффициентийг урт хугацаанд тогтвортой байлгах талаар авч хэрэгжүүлсэн, бодож боловсруулсан төлөвлөгөө зэрэг болно.